

Элч Нарын Тунхаг

6-р хичээл

АВРАЛ

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2012 Гурав Дахь Мянган Үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Библийн бүх эшлэлийг Ариун Библи 2019 (АВ2019), Ариун Бичээс Нийгэмлэг.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

Гурав дахь мянган үйлчлэл нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчлэл бөгөөд дараах талбаруудад чиглэдэг:

Библийн Боловсролыг. Бүх дэлхийд. Үнэгүйгээр.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид нь теологийн мэргэжлийн сургагч багш нар, орон орны орчуулагч нар маань теологийн мэдлэгтэй зэрэг давуу талтай юм. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.thirdmill.org цахим хуудсаар зочлоорой.

Элч нарын тунхаг

6-р хичээл

АВРАЛ

Гарчиг

УДИРТГАЛ	1
УУЧЛАЛ	1
Гэм Нүглийн Асуудал	2
Гэм Нүглийн Тодорхойлолт.....	2
Гэм Нүглийн Гарал Үүсэл.....	4
Гэм Нүглийн Үр Дагавар.....	5
Тэнгэрлэгн Нигүүлсэл.....	6
Эцэг	6
Хүү.....	7
Ариун Сүнс.....	8
Хувь Хүний Үүрэг	9
Нөхцөл Шаардлага.....	9
Арга Замууд.....	11
АМИЛАЛ	15
Хараал	16
Сайнмэдээ	17
Хуучин Гэрээ.....	18
Шинэ Гэрээ	20
Есүсийн амилал.....	21
Золилт	22
Одоогийн Амьдрал.....	22
Завсрын үе	23
Шинэ Амь Амьдрал	25
МӨНХ АМЬ	25
Хугацаа	26
Онцлог Чанар	27
Байршил.....	30
ДҮГНЭЛТ	31
ХАМТРАГЧИД	32
ҮГСИЙН ТАЙЛБАР	34

Элч нарын тунхаг

6-р хичээл

АВРАЛ

УДИРТГАЛ

Энэ цуврал хичээлээрээ Элч нарын тунхаг нь анхандаа Христитгэгчид баптисм хүртэхдээ итгэлээ тунхаглан уншдаг байсан итгэлийн хураангуй байсан хэмээн үзсэн шүү дээ. Яг энэ талаас нь харвал тэдний хувьд итгэлээ тунхаглахын хамгийн сэтгэл догдлуулсан хэсэг нь аврагдсан гэдгийг нь илэрхийлж буй тунхгийн тунхаглалууд байсан нь тодорхой харагддаг.

Бидний хувьд ч бас тийм биш гэж үү? Бид агуу Эцэг Бурхан, Хүү Бурхан, Ариун Сүнс Бурханд хайртай. Мөн бид Түүний байгуулсан чуулганыг эрхэмлэн хайрладаг. Гэхдээ бидний хамгийн том баяр хөөр бол аврал биднийх гэдэг сайн мэдээ юм шүү дээ. Бурхан бидэнд хайртай, Тэр бидний гэм нүглийг уучилсан. Тэрээр одоо ба ирээдүйд маань ч зориулан бидэнд онцгой төлөвлөгөө бэлдсэн гэдгийг мэдээд бид баярлан хөөрдөг.

Энэ бол Элч нарын тунхаг цуврал хичээлийн маань "Аврал" гэдэг сэдэвтэй зургаадугаар хичээл юм. Энэ хичээлээрээ бид элч нарын тунхаг дахь уучлал болон мөнх амийн тухай сайн мэдээнд итгэдэг итгэлээ хүлээн зөвшөөрдөг тунхаглалуудын тухай үзэх болно.

Бичвэрт "аврал" гэдэг үгийг олон янзаар ашигласан байдаг нь Христийн доторх бидний аврал ч мөн олон талтайг харуулдаг. Орчин цагийн Христитгэгчид "аврал" гэдэг үгийг ашиглахдаа Христ Өөрийн үхлээр зольж авсан ерөөлүүдийг хүлээн авах тухай боддог. Энэ нь сүнсээрээ дахин төрж, Бурхантай эвлэрэхээс эхлэн, ариуслын үйл явцаар үргэлжилж, шинэ тэнгэр ба газар дахь алдаршууллаар оргил цэгтээ хүрэх тухай байдаг.

Элч нарын тунхагт авралын энэ талыг ийнхүү хэлсэн байдаг:

Би...

Гэмийн уучлал,

Биеийн дахин амилал

Мөнхийн амьдралд итгэдэг.

Уучлал, амилал болон мөнхийн амь гэсэн гурван гол санаагаар авралын талаарх Библийн тайлбар дуусахгүй ээ. Гэхдээ энэ гурав бол итгэгч бүрийг аврахдаа Бурхан чухам юу хийдэг үйлсийг тунхагладаг Элч нарын тунхаг дахь үндсэн тунхаглалууд юм.

Бид Элч нарын тунхаг дахь авралын тухай ярихдаа бид эдгээрийг тус бүрд нь авч үзэх болно. Нэгдүгээрт, бид гэм нүгийн уучлалын тухай ярилцана. Хоёрдугаарт, бид биеийн амиллын тухай үзнэ. Харин гуравдугаарт, бид мөнхийн амьдралын мөн чанарын тухай үзэх болно. Ингээд бидний сайн мэдэх сэдэв болох гэм нүглийн уучлалын тухай эхлээд харцгаая.

УУЧЛАЛ

Элч нарын тунхагт уучлал гэж чухам ямар утгаар хэлсэн бэ гэдгийг ойлгохын тулд бид үүнтэй холбоотой гурван асуудлыг хөндөх болно. Нэгдүгээрт, уучлалыг зайлшгүй хэрэгтэй болгодог гэм нүглийн асуудал. Хоёрдугаарт, уучлалыг боломжтой болгодог тэнгэрлэг нигүүлсэл. Харин гуравдугаарт, уучлагдахын тулд бидний хийх ёстой үүрэг хариуцлагын тухай тус тус авч үзнэ. Ингээд эхлээд гэм нүглийн асуудлын талаар ярилцъя.

ГЭМ НҮГЛИЙН АСУУДАЛ

Библид итгэдэг Христитгэгчид нь Есүс бидний гэм нүглээс болж үүссэн асуудлыг шийдэхийн тулд үхсэн гэдгийг мэднэ. Гэм нүгэл биднийг Бурханы ерөөлөөс салгаж, Түүний хараал дор оруулдаг. Бид энэ асуудлаас өөрсдийн хүчээр гарах ямар ч арга зам байхгүй. Гэм нүглийн асуудал гэдгээр илэрхийлж байгаа гол санаа бол гэм нүгэл биднийг ялладаг явдал юм. Тиймээс Христгүйгээр гэм нүглийн хүлээс ба үр дагавраас бид өөрсдийгөө аврах ямар ч боломжгүй.

Гэм нүглийн асуудлын тухай Библид юу гэж заадгийг бид гурван хэсэгт хувааж үзнэ. Нэгдүгээрт, бид гэм нүглийн талаарх Библийн тодорхойлолтыг үзнэ. Хоёрдугаарт, бид хүн төрөлхтний гэм нүглийн гарал үүслийн тухай ярилцана. Харин гуравдугаарт, бид гэм нүглийн үр дагаврын тухай судлах болно. Ингээд гэм нүглийн тодорхойлолтыг эхлээд харцгаая.

Гэм Нүглийн Тодорхойлолт

Библид гэм нүглийг янз бүрээр бичсэн байдаг. Энд гэм нүгэлтэй байдлыг ёс бус байдал, тэрслэл, алдаа зөрчил, гэм буруу, ёрын муу, буруу сонголт гэх мэт олон янзын үгээр дүрсэлсэн байдаг. Гэхдээ үг бүр нь гэм нүглийг ойлгоход бидэнд тусалдаг.

Гэхдээ Библид гэм нүглийг онолын хувьд өөрийн өнцгөөс тайлбарлахдаа нэг үгэнд бусдаас нь илүү ач холбогдол өгсөн байдаг. Энэ бол ёс бус байдал юм. Библийн үгсийн санд гэм нүгэл гэдэг нь үндсэндээ Бурханы хуулийг зөрчих явдлыг хэлдэг. 1 Иохан 3:4-р эшлэлд Иохан энэ тухай хэлсэн байдаг. Энд:

"Нүгэл үйлддэг хүн бүр ёс бусыг үйлддэг. Нүгэл бол ёс бус юм" гэжээ (1 Иохан 3:4).

Мөн Ром 7:9-25 болон 1 Коринт 15:56 зэрэг эшлэлүүдэд ч гэм нүглийг ёс бус гэдгийг онцолсон байдаг. Гэм нүглийн тухай энэ үндсэн ойлголт нь Христитгэлийн олон өөр өөр уламжлалт теологид тусгалаа олсон байдаг.

Жишээ болгон Вэстминстерийн Богоино Асуулт Хариултын 14-р асуулт хариултыг сонсоцгооё. Асуулт:

"Гэм нүгэл гэж юу вэ?"

Хариулт нь:

"Гэм нүгэл гэдэг нь Бурханы хуульд нийцэх хүсэлгүй байх эсвэл зөрчих явдал юм" гэжээ

Энд Бурханы хуулийг зөрчих ерөнхий хоёр арга замыг тодорхойлсныг анзаарав уу. Энэ нь хуулиар хийх хэрэгтэй зүйлээ хийхгүй байх мөн хуулийг зөрчих гэсэн хоёр зүйл байна.

Нэг талаар хуулиар хий гэсэн зүйлийг хийхгүй байх нь Библийн тушаалуудыг биелүүлэхгүй байгаа хэрэг юм. Үүнийг ихэвчлэн эс үйлдэх гэм нүгэл гэдэг. Учир нь энэ нь бид хийх ёстой зүйлээ хийхээс цааргалж, үл хайхардаг гэсэн үг юм. Нөгөө талаар хуулийг зөрчих гэдэг нь Бичвэрийн хориглосон зүйлсийг үйлдэхийг хэлдэг. Ийнхүү хууль зөрчихийг үйлдэх гэм нүгэл гэдэг. Учир нь бид бодол, мэдрэмж, үйлдлээрээ санаатайгаар Библид хориглосон зүйлсийг хийж нүгэл үйлддэг гэсэн үг.

Тэгэхээр Бурханы хууль нь гэм нүглийг тодорхойлдог хэм хэмжээ болдог юм бол энэ нь санаандгүй эсвэл тохиолдлоор бий болсон зүйл биш гэдгийг онцлох нь зүйтэй. Харин эсрэгээрээ хууль нь Бурханы төгс чанарын тусгал байдаг. Ром 7:12 дээр Паул хуулийг юу гэж тайлбарласныг сонсоцгооё. Энд:

"Угтаа хууль бол ариун, бас тушаал ч ариун, зөв бөгөөд сайн юм" гэжээ (Ром 7:12).

Энэ эшлэлд Паулын хэлснээр Бурханы тушаалууд яг Бурхантай адил үргэлж ариун, зөв бас сайн байдаг гэжээ. Бурханы тушаалууд Түүний мөн чанартай нийцэж байдаг байх нь.

Хэрэв бид Бурханыг хайрладаг бол тушаалуудыг нь ч дагадаг гэж Библид хэлсэн нь ч ийм учиртай. Бид Бурханд хайртай бол Бурханы хууль зэрэг Түүний тусгал болсон бүхнийг хайрлах болно. Дэд хууль 5:10 болон 6:5-6, Матай 22:37-40, Иохан 14:15-24 зэрэг өөр олон эшлэлээс бид энэ тухай харж болно. 1 Иохан 5:3-р эшлэлд Иохан юу гэж хэлснийг сонсоцгооё. Тэрээр энд:

"Түүний тушаалуудыг сахих нь Бурханыг хайрлах явдал юм" гэжээ (1 Иохан 5:3).

Бурханыг хайрладаг гэдгээ бид тушаалуудыг нь сахиснаараа нотолдог. Тиймээс бид хуулийг нь зөрчвөл Бурханыг хайрлахгүй байна гэсэн үг. Тэгвэл бид гэм нүгэл хийж байгаа хэрэг мөн.

Библид Бурханыг хайрлах, Бурханыг дуулгавартай дагах хоёр хоорондоо маш уялдаа холбоотой байдаг. Ганцхан Бурханыг хайрлах нь Бурханыг хайрла гэсэн тушаалыг биелүүлж буй хэрэг биш гэдгийг бид юуны өмнө ойлгох хэрэгтэй. "Чи надад хайртай бол" гэж Библид хэлэхэд эсвэл "Чи надад хайртай бол тушаалуудыг минь сахь" гэж Христ бидэнд хэлэхэд энэ нь өмнө нь төсөөлж байгаагүй үүрэг хариуцлага төвтэй, хүнд хүчир ажил мэт бидэнд санагдаж болох юм. Гэхдээ үнэхээр хайртай бол, Бурхан дотор баярлан бахадсан мөн сайн дураар өөрийгөө зориулах сэтгэл байгаа бол үүний үнэн бодит илэрхийлэл нь бүрэн дүүрэн дуулгавартай байх хүсэл тэмүүлэл юм. Яагаад гэвэл энэ нь таны хайрладаг, баясан бахаддаг тэрхүү Бурхандаа таалагдах гэсэн хүсэлд тань суурилсан байдаг. Энэ нь "Бурханы зам" нь Түүний зан чанар шиг найдвартай бөгөөд таны сайн сайхны төлөө гэсэн итгэлд үндэслэдэг.

-Др. Глен Ж. Скоржие

Бид Бурханыг хайрлахдаа бүтэлгүйтвэл Түүний эсрэг тэрсэлж, хуулийг нь зөрчиж, ёр мууг үйлдэн, бурууг сонгож, ариун, зөвт хийгээд сайн чанарыг нь гутаан, гэм нүгэл үйлддэг. Харин бид Бурханыг гэсэн хайраараа хөтлөгдвөл Түүний хүсэл ба тушаалуудыг өөрсдийнхөөсөө дээгүүр тавьж чадна. Үр дүнд нь бид гэм нүгэл үйлдэхээс, мөн түүний аймшигт үр дагавраас зайлсхийж чадна.

Гэм нүгэл бол Бурханы хуулийг зөрчих явдал юм гэдгийг үзсэн тул одоо хүн төрөлхтний гэм нүглийн гарал үүслийн тухай судалцгаая.

Гэм Нүглийн Гарал Үүсэл

Эхлэл номын 3-р бүлэгт болдог үйл явдлуудыг бид бараг бүгдээрээ мэднэ шүү дээ. Бидний анхны эцэг эх болох Адам Ева хоёр сайн мууг мэдүүлэгч хориотой модны жимсийг идсэнээс болж Бурханы эсрэг тэрсэлсэн. Энэ үйлдлийг Библид ганц хүний явдал гэж үзээгүй. Үүнээс болж хүн төрөлхтөн тэр чигээрээ гэм нүгэлтэй болж завхарсан. Теологичид энэ үйл явдлыг хүн төрөлхтний уналт эсвэл зүгээр л Уналт гэж нэрлэдэг.

Эхлэл 1:26-31-р эшлэлд Бурхан хүн төрөлхтнийг анх бүтээх үед хүмүүс маш сайн бүтээл байсан тухай өгүүлдэг. Энд буй "Сайн" гэдэг нь бид яг л Бурхан биднийг ямар байгаасай гэж хүсэж байсан шиг байсан гэсэн үг. Бидний анхны өвөг дээдэс ёс суртахууны хувьд цэвэр тунгалаг Бурханы дүр төрх байсан ба Бурханы бүтээсэн дэлхийг захиран, Бурханд үйлчлэхэд төгс тохирсон байв.

Ром 5:12 дээр Паулын тодорхойлсноор гэм нүгэл Уналтаас өмнө хүн төрөлхтний дунд байгаагүй гэжээ. Хүн огт гэмгүй, гэмд автаагүй, гэмээс болж завхраагүй, гэм бидний дотор үгүй байсан.

Гэвч огтоос гэм нүгэл хийгээгүй байх үедээ ч хүн гэм нүгэл хийх боломжтой байсан. Бурхан Адам Ева хоёрыг бүтээгээд Еден цэцэрлэгт амьдруулж, олон зүйлийг тэдэнд илчлэн ойлгуулж байсан. Харин Бурхандаа үйлчлэх хүсэлтэй эсэхийг нь шалгахын тулд нэг л тушаалыг бүхний түрүүнд тэдэнд өгсөн. Эхлэл 2:16:17-р эшлэлд Бурхан Адам Ева хоёрт сайн мууг мэдүүлэгч модноос бусад ямар ч модны жимснээс идэхийг зөвшөөрсөн. Энэ хуулийг зөрчих боломж нь Адам Ева хоёрт гэм нүгэл үйлдэх боломж байсныг харуулдаг.

Харамсалтай нь Эхлэл 3:1-6-р эшлэлээс бид могой Еваг мэхэлж хориотой жимснээс идүүлснийг олж мэддэг. Дараа нь Ева тэр жимсийг Адамд өгч, Адам ч бас идсэн. Адам Ева хоёр Бурханы зөвт хуулийг зөрчиж, санаатайгаар гэм нүгэл үйлдсэн. Илчлэл 12:9-д могой нь үнэндээ Сатан байсныг тодорхой хэлсэн байдаг. Мөн 1 Тимот 2:14-р эшлэлд Еваг мэхлэгдсэн гэдгийг ч тодорхой өгүүлдэг. Гэхдээ Сатаны сорилт, Евагийн мунхаглалын аль нь ч тэдний гэм нүглийг цагаатгаж чадаагүй юм. Адам Ева хоёр сайны оронд хорон мууг сонгосон буруутай.

Эдгээр үйл явдлуудаас бид нүгэл нь үндсэндээ Бурханы хууль, Түүний илчлэгдсэн хүслийг зөрчих явдал гэдгийг дахин нэг удаа харлаа. Бурханы илчилсэн хуулиас өөрөөр бид бодох, ярих, үйлдэх бүрдээ сайны оронд хорон мууг сонгодог. Мөн хэдий мэхлэгдэж, хууртагдсанаас болж гэм нүгэл үйлдсэн байсан ч Бурхан бидний хийсэн зүйлд хариуцлага тооцох л болно. Тиймээс л Бурханы үгийг бид зүрхэндээ хадгалах нь чухал байдаг. Ийнхүү бид үүнийг зөвхөн мэдээд зогсохгүй хайрлаж чадах юм. Бурханы хуулийг мэдсэнээр гэм

нүглийг таньж, мэхлэгдэхгүй байж чадна. Бурханы хуулийг хайрлах үед Бурханд дуулгавартай байх сонголтыг хийхэд амар болдог.

Ингээд гэм нүглийн тодорхойлолт ба гарал үүслийнх нь тухай бид ярилцлаа. Одоо бүгдээрээ гэм нүглийн үр дагаврыг үзэхэд бэлэн болжээ.

Гэм нүглийн үр дагавар

Адам Ева хоёрыг гэм нүгэл үйлдсэний дараа Бурхан хүн төрөлхтнийг бүхэлд нь шүүж, хараасан гэдгийг Библид тодорхой өгүүлдэг. Энэ хараал тэдний оршихуйн бүхий л зүйлст нөлөөлсөн. Үүнээс тэр даруйдаа үүссэн үр дагавар нь сүнслэг үхэл байсан гэдгийг Иохан 5:24-25, Ефес 2:1-5, мөн Колоссай 2:13-14 зэрэг эшлэлд дурдсан байдаг. Иеремиа 17:9 болон Ром 7:18–8:11-р эшлэлүүдээс харвал нүгэл нь бидний бие махбод ба сүнсийг завхруулсан гэдгийг харж болно. Энэ нь бие махбодын үхлийг авчирсан болохыг Эхлэл 3:19 болон Ром 5:12-р эшлэлээс бид уншдаг. Эцэст нь, гэм нүгэл хүн төрөлхтөнд Бурханы шүүлтийн улмаас тамд мөнхөд зовох тавиланг авчирсан гэдгийг бид мөн Матай 5:29-30-р эшлэлээс олж мэддэг.

1892 онд амьдарч байсан пастор Чарлес Спөржеон Адам Ева хоёрын дээрх Бурханы хараалын тухай Хараал арилсан хэмээх номлолдоо дурдсан байдаг. Түүний юу гэж хэлснийг хамтдаа сонсоцгооё. Энд:

"Тэр хараалд чухам юу байдаг вэ? Үүнд үхэл буюу бие махбодын үхэл бий... Үүнд сүнсний үхэл болох дотоод амь, сүнсний минь бөхөл бий. Энэ амь нь Адамын дотор байсан ч, одоо үгүй болсон бөгөөд зөвхөн Ариун Сүнсээр л сэргээгдэх тэр амь юм... Мөн энэ хараалд хамгийн эцсийн, хамгийн аймшигт үхэл болох мөнхийн үхэл бий... энэ үхлийг "там" гэсэн аймшигтай, муухай ганц үгэнд багтаан хэлж болно" гэжээ.

Илүү муу нь гэвэл, Адам Ева хоёрын гэм нүглийн үр дагавар нь бүх хүн төрөлхтөнд, тэднээс гаралтай бүхий л үр удамд нь дамжсан хэрэг байлаа. 1 Хаад 8:46, Ром 3:9-12, Галат 3:22, мөн Ефес 2:3 зэрэг эшлэлээс бид гэм нүгэл дэлхий дахинаа тархсан тухай харж болно. Ром 5:12-19-р эшлэлд Паул Адамын гэм нүглийн тухай юу гэж хэлснийг сонсоцгооё. Энд:

"Нэг хүнээр ертөнцөд нүгэл, нүглээр үхэл орж ирсэн бөгөөд бүгд нүгэл үйлдсэн тул бүх хүнд үхэл иржээ... Учир нь ганц хүний дуулгаваргүйгээс болж олон хүн нүгэлтэн болсны адил..." гэжээ (Ром 5:12, 19).

Өмнөх хичээлээр үзсэнчлэн, Адам бүх хүн төрөлхтнийг төлөөлсөн гэрээний төлөөлөгч байсан. Тийм ч учраас Паул Адамын гэм нүгэл түүний бүх үр удамд хамаатай болсон гэжээ. Үүнээс болж бид төрөлхийн гэм нүгэлтэй болсон. Бид энэ дэлхийд гэм нүгэлтэй, өвчин зовлонг үүрэн мэндэлж, бие махбодоороо үхэх тавилантай болсон.

Хэтрүүлэг гэхэд ч хэцүү. Гэм нүглийн үр дагаврыг бид бүрэн ойлгох боломжгүй. Харин бидний гэм нүгэл бол Бүтээгчийнхээ эсрэг тэрслэл юм. Энэ бол Бүтээгчээсээ алдрыг булаахыг оролдсон хэрэг. Хуулийг зөрчиж, Түүний алдар суунд хүрээгүй явдал мөн. Ерөөсөө бид өөрсдийгөө Түүний дайснууд болгосон гэсэн үг. Бурхан Өөрөө ариун учраас гэм нүгэл бидний

Бурхантай харилцах харилцааг нураасан. Тэр гэм нүглийг харж үзэхгүй. Тэрээр ариун байдлынхаа улмаас гэм нүглийн дээр уур хилэнгээ гарцаагүй буулгах ёстой. Тиймээс бид хүмүүний гэм нүгэлтэй байдлыг харахдаа бидний гол асуудал чухам юу болохыг олж хардаг. Энэ нь мөн бид өөрсдийнхөө тухай мэдэх хэрэгтэй бүх зүйл юм. Гэм гэдэг бол богинохон, гурван үсэгтэй сэтгэл судлал л гэсэн үг. Энэ нь бидэнд толинд харж байгаа зүйлээ ойлгоход, өөрсдийнхөө тухай танихад тусалдаг юм. Мөн гэм бидэнд энэ хүндрэлтэй байдлаас өөрсдийгөө аварч чадахгүй гэдгийг ч сануулдаг. Зөвхөн Бурхан л аварч чадна. Тэр Христийн дотор биднийг авардаг.

-Др. Р. Алберт Мохлер, Жр

Гэм нүглийн асуудал бол үнэхээрийн аймшигтай. Хүн төрөлхтөн тэр чигээрээ төөрч будилж, буруутгагдсан. Бидэнд өөрсдийгөө аварч золих ямар ч арга зам байхгүй. Бид Бурханы шүүлт дор насан туршид зовох заяатай болсон. Бид Түүний тааллыг дахин олж, гэм нүглээ цайруулж чадахгүй. Бурханы нигүүлсэнгүй өршөөл уучлалаас өөр авралд хүрэх ямар ч найдвар үгүй билээ.

Бид гэм нүглийн бэрхшээлийн тухай үзлээ. Тэгэхээр одоо бүгдээрээ гэм нүглийн уучлалын тухай яриагаа уучлалыг боломжтой болгодог тэнгэрлэг нигүүлслийн тухай яриагаар үргэлжлүүлцгээе.

Тэнгэрлэг нигүүлсэл

Бурхан хайр өршөөлөөр дүүрэн учраас хүн төрөлхтнийг бүхэлд нь гэм нүглийн хараал дор байлгахыг хүсээгүй. Тэрээр хүн төрөлхтөн газар дэлхийг дүүргэн захирч, үүнийг оршихуйд нь зохистой хаант улс болгох төлөвлөгөөгөө орхиогүй. Тиймээс Тэрээр гэм нүглийн асуудлыг шийдвэрлэх Аврагчийг илгээсэн. Тэр Аврагч нь харин Түүний Хүү, Есүс Христ байсан юм.

Есүс Аврагч учраас биднийг буруутгал болон завхралаас авардаг. Тэр биднийг Өөртэйгөө эвлэрүүлдэг. Тэр бидний энэ дэлхий дээр Бурханы хаанчлалыг байгуулах чадварыг сэргээдэг. Бурханы төлөвлөгөө нь хэзээ ч авралыг олж авах гэсэн хүмүүний өчүүхэн чадварт тулгуурладаггүй. Харин онцгой нэгэн төлөөлөгч болох Эзэн Есүс Христээр дамжиж бидэнд ирэх Бурханы нигүүлсэл, болзолгүй таалалд тулгуурласан юм. Энэ талаар Ром 3:23-24-р эшлэлд өгүүлсэн байдаг. Энд:

"Бүгд нүгэл үйлдсэн тул Бурханы алдар сууд хүрдэггүй авч, Христ Есүсийн золилтоор дамжин Бурханы нигүүлслээр үнэгүй зөвтгөгдөнө" гэжээ (Ром 3:23-24).

Тэнгэрлэг нигүүлслийн үйлс тул үүнд Эцэг, Хүү, Ариун Сүнс гэсэн Гурвалын бодгаль бүр оролцдог. Ингэхдээ энэ нь Эцэгээс эхлэлтэй байдаг.

ЭЦЭГ

Аврал бол угтаа Гурвалын ажил юм. Өөрөөр хэлбэл Эцэг санаачилж, Хүү нь гүйцэлдүүлж, Ариун Сүнс хэрэгжүүлдэг. Бид Эцэг-Хүүгийн

харилцааны тухай бодохдоо үнэндээ Эцэг, Хүү, Ариун Сүнсний тухай бодох хэрэгтэй. Учир нь энэ гурав гурвуулаа бидний авралыг төлөвлөхөд оролцсон. Бурханы бодгаль бүр нь нигүүлсэл, хайр, өршөөлөө үзүүлдэг төдийгүй уур хилэн, зөвт байдал, шүүлтээ ч мөн буулгадаг. Тиймээс Эцэг санаачлагч гэж харагдаж байгаа ч Хүү болон Ариун Сүнснээс тусдаа ганцаар үүнийгээ хийгээгүй гэсэн үг.

-Др. Стефен Ж. Вэллум

Эцэг Өөрөө төлөвлөсөн учраас уучлал Түүнээс эхлэлтэй. Эцэг Өөрийн Хүүг энэ дэлхий уруу илгээж, Аврагч байхаар томилсон гэдгийг Шинэ Гэрээнд тодорхой заасан байдаг. Иохан 3:16:18, Үйлс 2:34-36, мөн Еврей :1-2 зэрэг эшлэлээс бид энэ тухай харж болно.

Эцэг Есүсийг Өөрийн хүмүүсийн Аврагч болгон хүчирхэгжүүлж, Есүсийн загалмай дээрх золиосыг гэм нүглийн төлөөс болгон хүлээж авахаа амласан. Иохан 10:14-18, Колоссай 1:18-20 болон Еврей 2:10 зэрэг эшлэлээс бид Эцэгийн эдгээр үүрэг оролцоог хардаг.

Үнэндээ Ром 3:25-р эшлэлд Есүсийг золиос болгон өргөсөн нь Эцэг Өөрөө байсан гэдэг. Паул чухам юу гэж хэлснийг сонсоцгооё. Энд:

"Бурхан Түүнийг эвлэрүүлэл болгож нийтэд харуулсан" гэжээ (Ром 3:25).

Эцэг бол авралын агуу архитектурч нь мөн. Бидний гэм нүглийг уучилж, биднийг ерөөх нь Түүний нигүүлсэнгүй хийгээд өршөөнгүй төлөвлөгөө юм. Мөн авралыг боломжтой бас баталгаатай болгох нь Түүний эрх мэдэл билээ.

Хүмүүсийнхээ эсрэг чиглэсэн тэнгэрлэг Эцэгийнхээ уур хилэнг намжаахаар Есүс загалмай дээр чармайн хичээж байгаа гэсэн санаа яваад байдаг. Энэ нь Есүсийг хайраар дүүрэн, харин Эцэгийг тийм биш мэтээр харагдуулдаг. Гэвч үнэндээ энэ бол Есүс Христийн золилтоор чухам юу болсон талаарх ноцтой буруу дүрслэл юм. Загалмай дээр гүйцэлдүүлсэн Есүсийн үйлс нь Өөрийн хүмүүсийг гэсэн Эцэгийн хайрын илэрхийлэл байсан юм. Есүс Эцэгийнхээ хайрын үр дүнд энэ дэлхийд ирж, загалмайг үүрсэн тухай Шинэ Гэрээнд хичнээн удаа дурдсан байдгийг тунгааж нэг үзээрэй. Христитгэгч болоод ихэнх хүмүүс Иохан 3:16 дээрх "Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн..." гэдэг эшлэлийг хамгийн түрүүнд цээжилдэг шүү дээ. Тэгвэл энэ эшлэлд хэний хайрыг илүү онцолсон байна вэ? Мэдээж би Есүсийн хайрыг өчүүхэн ч багасгах гээгүй шүү. Гэхдээ Хүүгээ өгсөн Бурхан Эцэгийн хайрыг энд онцолсон байна шүү дээ.

-Др. Ж. Лигон Дункан III

ХҮҮ

Бидний авралыг бүрэн гүйцэд болгосон тэнгэрлэг нигүүлсэлд Хүү ч бас оролцсон. Тэр бол бидний Аврагч.

Эцэгийн амлалтын биелэл болж Хүү энэ дэлхий руу илгээгдсэн. Ингэхдээ хүн төрөлхтний нүглийг цагаатгахын тулд Есүс хүмүүний дүрээр биежин, он удаан жил хүсэн хүлээсэн Мессиа болж ирсэн билээ. Ром 3:25-26, Еврей 2:14-17, мөн 10:5-10 зэрэг олон олон эшлэлээс бид энэ сургаал номлолыг харж болно.

Есүс нүгэлтнүүдийн оронд загалмай дээр амиа өгснөөр тэдний нүглийг цагаатгасан. Нүглийн маань улмаас бидэнд оноогдсон тэнгэрлэг хараалыг Тэрээр үүрсэн юм. Мөн Түүний төгс зөвт байдал биднийх болж, бид нүгэлтнүүд бус Бурханы дуулгавартай хүүхдүүд гэж тооцогдох боломжтой болсон. Энэ дүр зургийг харж болох хэдхэн эшлэлийг л дурдвал Иохан 10:14-18, Галат 2:20, 2 Коринт 5:21, мөн Еврей 10:9-14 гээд олон эшлэл бий.

Энэ тухай Ефес 1:7-р эшлэлд Паул өгүүлсэн. Тэрээр энд:

"Түүний нигүүлслийн баялгаар Түүн дотор, цусаар нь бидэнд золилт, гэм нүглийн маань уучлал бий" гэжээ (Ефес 1:7).

Бурханд зүгээр л ойшоохоо больсон учраас бидний гэмийг уучилчхаагүй юм. Харин Бурхан гэм нүглийг Христ дотор шийтгэсэн учраас л бидний гэм нүгэл уучлагдсан. Тиймээс л Библи бидэнд авралдаа итгэл дүүрэн байхыг уриалдаг билээ.

Эцэг, Хүү хоёрын эдгээр ажлуудаас гадна уучлал өршөөл нь нөгөө талаас Ариун Сүнсний тэнгэрлэг нигүүлслийн үр дүн мөн.

АРИУН СҮНС

Ариун Сүнс бол уучлалыг бидний амьдралд хэрэгжүүлдэг Гурвалын бодгаль юм. Эцэг анхлан төлөвлөж, Хүү эвлэрүүллийг гүйцэлдүүлсэн. Тэгсэн хэдий ч Ариун Сүнс ажлаа хийх хүртэл бидний гэм нүгэл уучлагдахгүй.

Бид итгэгч болох үед Ариун Сүнс бидний өмнө үйлдсэн бүхий л гэм нүглийг уучлан, Бурхантай эвлэрүүлдэг. Мөн Иохан 3:5-8-р эшлэлд Есүсийн хэлсэнчлэн Ариун Сүнс нь бидний сүнсийг шинэчлэн, шинэ сүнслэг амийг өгдөг. Үйлс 11:18 дээр үүнийг "амь өгөх гэмшил" гэж нэрлэдэг. Учир нь шинэчлэлт өөрчлөлт болон итгэл хэзээд гэм нүглээ хүлээн зөвшөөрсөн гэмшил гашуудалтай зэрэгцэн явдаг. Энэ санааг 1 Коринт 6:11 зэрэг олон хэсэгт баталгаажуулсан байдаг.

Ариун Сүнс бидэнд амьдралын маань туршид уучлал өршөөлөө үзүүлдэг. Тэр бидний итгэлийг батжуулж, өдөр бүр гэмээсээ эргэхэд хөтлөн дагуулдаг. Тийнхүү Тэрээр биднийг үргэлжлүүлэн уучилсаар байдаг. Ром 8:1-16, мөн Галат 5:5 зэрэг эшлэлүүдээс бид энэ тухай харж болно. Нэг жишээ болгон 2 Тессалоник 2:13 дээр Паул энэ талаар юу гэж бичсэнийг харцгаая. Тэрээр энд:

"Учир нь Бурхан та нарыг Сүнсний ариусгал ба үнэнд итгэх итгэлээр дамжуулан аврагдах анхны үр жимс болгон сонгосон ажээ" гэсэн байна (2 Тессалоник 2:13).

Энэ эшлэлд Паул биднийг гэм нүгэл ба зөвт бус байдлаас маань цэвэрлэдэг Ариун Сүнсний ажлаар дамжуулан итгэгчид аврагддаг гэжээ. Энэ нь Ариун Сүнсний хийдэг зүйл л уучлалыг бидний амьдралд хэрэгжүүлдэг гэсэн үг юм. Бид үнэнд итгэсэн хэвээр байвал Ариун Сүнс үргэлжлүүлэн уучлалыг өгсөөр л байдаг.

Эцэг, Хүү, Ариун Сүнс гурвуулаа бидэнд авралын нигүүлслээ өгдөг. Энэ бидний амьдалд хамгийн багадаа гурван талаар нөлөө үзүүлдэг. Нэгдүгээрт, бид гэм нүгэл үйлдчихээд Бурханаас уучлал ба авралыг гуйхдаа гуйлт хүсэлтээ гурвалын бодгаль бүрд хандан өргөх нь зүйтэй. Хоёрдугаарт, бид ерөөлүүдээ хүлээн авсан бол Бурханы гурвалд хандан талархах хэрэгтэй. Гуравдугаарт, Гурвалын бодгаль бүр биднийг хайрлаж, авралыг маань баталгаажуулахын тулд зүтгэдэг учраас бид авралдаа бүрэн итгэлтэй байж болно. Эцэг, Хүү, Ариун Сүнс бүгд хамтдаа бидний сайн сайхны төлөө, гэм нүглийн асуудлыг маань шийдэхээр ажилладаг билээ.

Ингээд бид гэм нүглийн уучлалыг нүглийн уучлал болон тэнгэрлэг нигүүлслийн талаас нь авч үзлээ. Одоо бүгдээрээ уучлагдахын тулд хувь хүн ямар үүрэгтэй байх тухай ярилцахад бэлэн боллоо.

ХУВЬ ХҮНИЙ ҮҮРЭГ

Бурхан хүн бүрийн гэм нүглийг уучилдаггүй гэдгийг Библид тодорхой заасан байдаг. Зарим хүмүүс уучлагдаж, зарим нь уучлагддаггүй. Яагаад ийм байдаг юм бол? Хүний зүгээс үзэхэд үүний учир шалтгаан бол уучлалын үйл явцад хувь хүний үүрэг хариуцлага чухал оролцоотой гэж харагддаг. Товчхондоо тэдгээр үүрэг хариуцлагаа биелүүлсэн хүмүүс нь уучлагдаж, харин биелүүлээгүй нь уучлагдахгүй гэсэн үг.

Хувь хүний үүрэг хариуцлагын тухай бид хоёр хэсэгт хуваан үзэх болно. Нэгдүгээрт, бид Библид уучлалын энгийн шаардлагууд гэж тодорхойлсон байдаг зарим нөхцөлүүдийн тухай ярилцана. Харин дараа нь уучлалыг хүлээн авах арга замуудын тухай үзнэ. Одоо эхлээд Библи дэх уучлагдах нөхцөлүүдийн тухай үзье.

Нөхцөл шаардлага

Библид уучлалын хоёр гол нөхцөлийг заасан байдаг. Уучлалыг авах хамгийн эхний нөхцөл шаардлага бол Бурханд итгэх итгэл юм. Библид итгэл нь олон талт ойлголт. Гэхдээ Бурханд итгэх итгэлийн тухай ярихдаа бид дараах байдлаар ойлгох хэрэгтэй болно. Энэ нь:

Бурханы тэнгэрлэг эрх мэдлийг хүлээн зөвшөөрч, Түүнд үнэнч байж, бидний аврагч Есүс Христийн нэрийн улмаас бидэнд хайр өшрөөлөө өгнө гэдэгт итгэнэ гэсэн үг.

Орчин цагийн хүмүүст ингэж хэлэхээр их сонин сонсогдож байж болох юм. Гэвч энэ төрлийн итгэлийг Библид "Бурханаас эмээх" хэмээн ихэнхдээ тодорхойлдог.

Жишээ нь, Дуулал 103:8-13-р эшлэлд уучлалын нөхцөлийг тодорхойлсон байдаг. Энэ нь:

"ЭЗЭН өрөвч, нигүүлсэнгүй, уурлахдаа удаан, хайр энэрлээр элбэг баян. Үргэлжид тэмцэлдэхгүй, уураа ч Тэрээр мөнхөд хадгалахгүй. Тэрээр хилэнцэд минь тааруулан хандаагүй билээ, гэм буруугаар маань ч бидэнд хариулаагүй билээ. Тэнгэр нь газраас өндөрт байдгийн адилаар түүний энэрэл хайр нь Түүнээс эмээгчдийн дээр үлэмж их байдаг. Өрнө нь дорноос хол байдаг адил гэмт үйлдлийг маань биднээс Тэрээр тийн холдуулсан. Эцэг

хүн хөвгүүдээ өрөвддөгийн адил ЭЗЭН Өөрөөс нь эмээгчдийг өрөвддөг" гэжээ (Дуулал 103:8-13).

Эзэнээс эмээдэг хүмүүс Түүний уучлалыг хүлээн авч, нүгэл нь зайлуулагддаг гэж хэлснийг анзаарав уу.

Яг үүнтэй адил санаа Библиэр дүүрэн бий. Жишээ нь, 2 Шастир 30:18-19-р эшлэл юм. Энд Эзэн зүрх сэтгэлээрээ Өөрийг нь эрэн хайдаг хүмүүсийг өршөөдөг гэж хэлсэн байдаг. Марк 4:12-р эшлэлд зөвхөн Эзэнийг ойлгож таньсан хүмүүс л Түүнээс уучлалыг эрэн хайж эргэж чадна гэж Есүс хэлсэн. Харин Үйлс 26:17-18-р эшлэлд уучлал зөвхөн Эзэний сүр жавхлан болон хүч чадлын үнэнийг харсан хүмүүсийнх гэж хэлсэн байдаг.

Тэгвэл Библи дэх уучлалын хоёр дахь нөхцөл бол эмтэрсэн зүрх юм. Эмтэрсэн зүрх гэдэг нь: Гэм нүгэлдээ чин сэтгэлээс гашуудах буюу Бурханы хуулийг зөрчсөндөө чин үнэнээр харамсан гэмших явдал юм.

Гэхдээ энэ нь баригдах вий эсвэл шийтгэл авах вий гэсэн харамсал биш. Харин энэ нь Эзэний шаардлагуудыг ариун гэдэгтэй санал нийлж, Түүнийг алдаршуулж, хүндэлж чадаагүйдээ сэтгэл нь эмтрэхийг хэлж байгаа юм.

Гэмшил гашуудал гэдэг нь бид буюу та бас би бүгдээрээ гэм нүглийн буруутгалыг мэдрэх тухай байдаг. Давидын Батшебатай завхайрсны дараах үеийг авч үзье л дээ. Тийм ээ, тэр Батшебагийн эсрэг нүгэл хийсэн. Мөн тэр Батшебагийн эр нөхрийн эсрэг нүгэл хийсэн. Тэр Хуучин Гэрээний чуулганы эсрэг нүгэл үйлдсэн. Гэвч эцсийн эцэст тэрээр "Таны эсрэг, зөвхөн таны эсрэг, би нүгэл үйлдэж, таны мэлмийд бузар мууг үйлдлээ" хэмээн өчсөн юм. Эндээс түүний зүрх сэтгэлийн гашуудал гэмшлийг та харж болно. Орчин цагийн үг хэллэгээр бол энэ нь "эмтэрсэн зүрх" юм. Бидэнд Ариун Сүнсээр биднийг эмтэлж, Бурханы оршихуйн өмнө эмтэрсэн байх тухай илэрхийлэх тийм л үг хэрэгтэй.

-Др. Дерек Томас

Жишээ нь, 2 Самуел 11-р бүлэгт Давид Батшебатай завхайрсныхаа дараа огтхон ч харамсаж гэмшээгүй. Тэр ч бүү хэл түүнийг жирэмсэн болсныг нуух гэж нөхөр Уриаг нь үхэлд хүргэсэн. Батшебаг жирэмсэн байх хугацаанд буюу хүүхэд нь төрөх хүртэл Давид өөрийн энэ үйлдэлд огтхон ч гэмшихгүй амьдарсаар л байсан. Гэтэл яг энэ үед нь эш үзүүлэгч Натан Давидын нүглийг буруушаасан тухай бид 2 Самуел 12-р бүлэгт гардаг. Тэгэхэд л Давид хийсэн гэмт хэргээ хүлээн зөвшөөрч, чин зүрхнээсээ гэмшсэн. Дараа нь тэрээр жинхэнэ эмтэрсэн сүнсээр Дуулал 51-р бүлгийг бичсэн юм. Энэ бол түүний чин зүрхний гашуудал, харууслаа илэрхийлсэн гэмшлийн дуулал болсон юм. Дуулал 51:6, 17-р эшлэлд Давид юу гэж хэлснийг сонсоцгооё. Тэрээр энд:

"Харагтун, сэтгэлийн гүнд үнэн байхыг та хүсдэг бөгөөд... Бурханы авах тахил нь эмтэрсэн сүнс юм. Эмтэрсэн, гэмшсэн зүрхийг Бурхан Та жигшихгүй" гэжээ (Дуулал 51:6, 17).

Бурханы уучлалыг хүлээн авахын тулд өөрийнх нь нүглийг Бурхан юу гэж харж буйг гүнээ ойлгох хэрэгтэйг Давид ухаарсан. Тэрээр хийсэн зүйлээ үзэн ядаж, үнэн сэтгэлээсээ гашуудах хэрэгтэй байсан.

Дуулал 32-ын 1 болон 2-р эшлэлээс бид үүнтэй адил эмтэрсэн зүрхийг харж болно. Энд сэтгэлдээ худал хуурмаггүй хүмүүст уучлал ирдэг гэсэн байдаг. Исаиа 55:7-р эшлэлд гэм нүглээ хаяж эргэсэн хүмүүст Бурханы өршөөл ирдэг гэсэн. Мөн Иремиа 5:3-р эшлэлээс бид нүглээ ухаараагүй зүрхээ хатууруулсан хүмүүст уучлал ирдэггүй болохыг хардаг.

Бурханы ариун байдалд оюун санаагаа төвлөрүүлснээр эмтэрсэн буюу гэмшсэн зүрх бий болдог гэж би боддог. Дуулгаваргүй хүмүүстэй нөхөрлөдөггүй, дуулгаваргүй байдлыг шүүдэг, нүгэлтнийг шийтгэдэг тэрхүү Бурханы тухай Библид Эхлэлээс Илчлэл хүртэл чухам юу гэснийг тунгаан бодсоноор бид тийнхүү эмтрэн ирдэг. Энэ нь Бурханы мөн чанар ариун гэсэн үг юм. Тэгээд бид Бурханы ариун байдлыг ойлгож ухаараад, өөрсдийн амьдралыг эргэн нэг хардаг. Тэгээд Бурханы үгийг дагалгүй гэм бурууг үйлдэж, дуулгаваргүй байдалд төөрөлдөн явахдаа Түүнийг үл хүндэлсэн олон алдаа хийснээ эргэцүүлэн боддог. Гэтэл одоо эргээд харахад миний хүртэх байсан тэр бүх шийтгэлийг Христ нуруундаа үүрч, зовлон тамлалыг эдэлсэн байна. Энэ бүхэн нь миний гэм нүгэл ямар аймшигтай байсныг надад харуулдаг. Тэдгээр гэм нүгэл нь зөвхөн Бурханы Хүү л миний төлөө амиа өгч байж цагаатгагдах боломжтой байж шүү дээ. Бурханы ариун байдлын гэрэлд миний гэм нүгэл ямар аймшигтай болохыг мөн үүнийг зайлуулахын тулд ямар их үнэ хөлс төлснийг ухаарснаар нүглийг улам илүү жигшиж, зүрх минь улам илүү даруусан эмтэрдэг. Ийнхүү би өөрийгөө Бурханд ариун байхаар зориулахын тулд, цагаатгал шаардлагатай гэм нүгэлдээ хэчнээн их харуусан гашуудаж буйгаа хэлэхийн тулд үнэн зүрхнээсээ дахин, дахин, дахин дахин эмтрэн ирдэг.

-Др. Ж.И.Пакер

Итгэгч эсвэл итгэгч биш байхаас үл хамааран итгэл ба эмтэрсэн зүрхний нөхцөл шаардлага гэдэг хүн бүрийн амьдралд чухал. Христийг Эзэнээ болгож амжаагүй байгаа хүмүүсийн хувьд энэ хоёр нөхцөл бол Бурхан дээр ирж, гэм нүглээ уучлуулж, Христ дотор шинэ амьдралаар амьдрах боломж юм. Харин аль хэдийн Эзэнийх болсон хүмүүсийн хувьд энэ хоёр нөхцөл шаардлага нь бидэнд итгэлдээ тууштай байж, үйлдсэн нүгэлдээ чин сэтгэлээсээ гэмшсээр байх ёстойг сануулдаг. Ийнхүү бид өдөр бүр уучлагдан, цэвэрлэгддэг билээ.

Ингээд уучлалыг хүлээн авахын тулд Бурханд итгэх итгэл болон зүрх сэтгэлдээ эмтрэн гэмших зайлшгүй нөхцөл шаардлагатай байдаг тухай бид үзлээ. Одоо бүгдээрээ уучлалыг хүлээн авах арга замуудын тухай үзье.

Арга замууд

Заримдаа Христитгэгчид нигүүлслийн арга зам болон нигүүлслийн үндэс суурь хоёрын ялгааг мэддэггүй. Үүнээс болж тэд нигүүлслийн арга замаар нигүүлслийг олж авах

гэж зүтгэн, Бурханыг хүчээр бидэнд нигүүлсэнгүй байлгах гэж оролддог. Тиймээс арга зам болон үндэс суурийг хооронд нь маш сайн ялгаж салгах хэрэгтэй. Энэ ялгааг ойлгохын тулд гэмтлээс болж эмчилгээ хэрэгтэй болсон хүний жишээг авч үзье л дээ. Эмчилгээний зардал өндөр байсан учраас тэр хүн хандиваар мөнгө цуглуулсан байна. Түүний эрүүл болох арга зам бол эмчилгээ байсан. Харин эрүүл болох санхүүгийн үндэс суурь нь хандив гэж хэлж болох юм.

Бид эдгээр ялгааг нэгтгэн дүгнэвэл үндэс суурь гэдэг бол аливаа үйлдэл, үр дагавар бий болох суурь хөрс нь юм. Харин арга зам гэдэг нь тухайн үйлдэл, үр дагаврыг авчрах арга хэрэгсэл, механизмыг нь хэлнэ.

Тэгвэл Бурханы уучлал, нигүүлслийг хүлээн авах үндэс суурь нь үргэлж дуулгавартай амьдрал ба загалмайн үхэл бүхий Христийн зүтгэл байдаг. Матай 26:28, Колоссай 1:13-14, мөн 1 Иохан 2:12 зэрэг эшлэлүүдээс бид энэ тухай харж болно. Уучлалыг үргэлж зүтгэж олдог. Гэхдээ уучлалыг бид өөрсдөө зүтгээд олчихдоггүй. Харин Христээр л үүнийг олж авдаг. Мөн тэр бүх нигүүлсэл бидний амьдралд орж ирэх арга зам нь итгэл юм. Бурханд шууд хандсан эсвэл нигүүлслийн арга замаар дамжуулан илэрхийлсэн аль нь ч бай итгэл бол Бурхан бидний амьдралд нигүүлсэл болон бусад ерөөлөө өгдөг гол арга зам нь билээ.

Итгэл ажилладаг хэд хэдэн арга замын тухай Бичвэрт дурдсан байдаг. Энэ хичээлийнхээ зорилгын хүрээнд бид тэдгээр арга замуудыг хоёр хэсэгт хураангуйлж үзнэ. Эхнийх нь залбирал юм.

Бичвэрт залбирлыг Бурханы нигүүлсэл, уучлалыг гуйн хүсэх энгийн арга зам гэж танилцуулсан байдаг. Тухайлбал, итгэлийн ба гэмшлийн залбирлууд бол Ариун Сүнс бидэнд уучлалыг өгөх боломжийг нээдэг итгэлийн илэрхийлэл гэж Библид маш олон удаа өгүүлдэг. Тэдгээр залбирлуудын үр нөлөөний тухай 1 Хаад 8:29-40, Дуулал 32:1-11, Үйлс 8:22, 1 Иохан 1:9 гэх мэт олон эшлэлд заасан байдаг.

Эзэнийг дөнгөж таньж мэддэг болсон хүмүүсийн хувьд нүглээ улайн гэмших залбирлууд нь Ариун Сүнс тэдний амьдралд уучлал бас авралыг анхлан авчрах боломжийг нээдэг арга зам гэсэн үг юм. Үйлс 11:18-р эшлэлд итгэлийн энэхүү залбирлыг "амь өгөх гэмшил" гэж хэлсэн нь ийм учиртай. Ер нь итгэгч бүрийн хувьд улайн гэмших залбирал нь Бурханы нигүүлслийг амьдралдаа хүлээн авсаар байх чухал арга зам мөн. 1 Иохан 1:9-р эшлэлд энэ тухай өгүүлдэг. Энд:

"Бид нүглээ улайвал итгэмжит, зөвт Тэрээр нүглийг маань уучилж, бүхий л зүй бусаас биднийг цэвэрлэнэ" гэжээ (1 Иохан 1:9).

Сайнмэдээний гайхамшигт үнэн бол Бурхан Христ бидний төлөө юу хийсэн бэ гэдэгт тулгуурлан бидний гэмийг үнэгүй уучилдаг явдал мөн. Бид энэ уучлалыг итгэлээрээ гуйн залбираад л авах боломжтой.

Юу гэхээр, Бурхан дээр ирээд "Тэнгэрлэг Эцэг минь, намайг өршөөгөөч" гэж хэлсэн бүгдийг Тэрээр уучилдаг гэж заавал Бурханы нигүүлслийг үнэгүйдүүлсэн хэрэг болно шүү дээ гэж олон хүн боддог. Гэвч үнэн хэрэгтээ энэ нь Бурханы нигүүлслийг өргөмжилдөг. Яагаад гэвэл бидний гэмшил биднийг аварч, Бурхан биднийг уучлах үндэс болдоггүй юм. Харин Тэрээр Өөрөө бидний гэм нүглийн уучлал ба

эвлэрүүллийн үндсийг боломжтой болгож өгсөн. Энэ бол цорын ганц Хүүгийнх нь туйлын эрхэм нандин, тоймгүй үнэ цэнтэй үхэл билээ.

-Др. Ж. Лигон Дункан III

Бурханы Хүү, Гурвалын хоёр дахь бодгаль болох Есүс Христ энэ дэлхийд ирээд гучин жилийг дорд байдлаар, хүмүүст үйлчлэн өнгөрөөсөн. Тэгээд Тэрээр зовж тарчлан, загалмай дээр амиа өгсөн. Тэрээр бидний гэм нүглийн шийтгэлийг үүрэхийн тулд загалмай дээр нүглийн маань өрийг төлсөн. Энэ бол үнэндээ бидний гэм нүглийн мөнхийн төлбөр, мөнхийн үнэ, асар том төлбөрийг нэгмөсөн төлсөн хэрэг байв. Тиймээс Түүний нигүүлсэл хямдхан зүйл биш ээ. Харин хүртэж болох хамгийн үнэтэй нигүүлсэл юм. Бид үүнийг үнэгүй хүлээн авсан. Гагцхүү Есүс бидний төлөө бүхнээ өгсөн учраас л тэр шүү дээ.

-Др. Марк Л. Страус

Түүний өмнө ирээд "Намайг уучлаач, Эзэн минь" гэж хэлсэн бүхэн уучлагддаг. Тэдний хүсэл гуйлт бахархмаар эсвэл маш сайн гэмшсэн болохоор биш. Харин Есүс биднийг Тэнгэрлэг Эцэгтэйгээ эргэн нэгдэн нөхөрлөхөд шаардлагатай бүхнийг хийсэн учраас тэр юм.

-Др. Ж. Лигон Дункан III

Одоо бид түр зогсон уучлалд хүрэх арга зам болдог гэм нүглээ улайн гэмших залбирал дээр нэмээд уучлалд хүрэх ер бусын, гайхалтай арга зам болдог зуучлан залбирлын тухай ярих хэрэгтэй. Зуучлан залбирал гэдгийг хэн нэгний өмнөөс зуучлах, гуйх, залбирах гэж тодорхойлж болно.

Үр нөлөөтэйгөөр зуучлан залбирсан хүмүүсийн олон жишээг Библид бичиж тэмдэглэсэн байдаг. Эзэн Мосегийн зуучлан залбирлын хариуд Израилын гэм нүглийг уучилсан тухай Тоолол 14:19-20-р эшлэл гардаг. Мөн Эзэн Хезекиагийн зуучлан залбирлын хариуд Алгасалд зохистойгоор бэлдээгүй хүмүүсийн нүглийг ч өршөөсөн талаар 2 Шастир 30:18-20-д өгүүлдэг. Бид Иов 1:5-р эшлэлээс хүүхдүүдийнхээ төлөө тогтмол үр нөлөөтэй зуучлан залбирдаг байсныг нь харж болно. Мөн Иаков 5:14-15-р эшлэлээс бид Иаков чуулганы ахлагчдад гэм нүгэл үйлдсэн хүмүүстээ уучлал өршөөлийг хэрхэн олох тухай заасныг харж болдог. Бурхан итгэмжтэй хүмүүсийнхээ зуучлан залбирал бүрд хариулж, уучлаад байдаггүй ч ийнхүү уучлах үе олон бий.

Хүмүүний зуучлан залбирлаас гадна, Хүү болон Ариун Сүнс хоёр ч хүмүүсийн төлөө зуучлан гуйдаг. Есүс зуучлан залбирч байсан тухай Исаиа 53:12, Ром 8:34, Еврей 7:25 зэрэг эшлэлүүдэд дурдсан байдаг. Харин Ром 8:26-27-р эшлэлээс Ариун Сүнсний зуучлан залбирлын тухай мөн харж болно.

Уучлалд хүрэх арга замын хоёр дахь ерөнхий ангилал бол сакрамент буюу орчин цагийн Протестант сүм чуулгануудын хэлж заншсанаар баптисм ба Эзэний зоогийн "ёслолууд" юм.

Тэгэхээр бид "сакрамент" гэдэг үгийг ашиглаж байгаа нь Ромын Католик Сүмийн Эзэний зоог болон баптисмын тухай үзлийг яриагүй гэдгээ тодорхой болгох хэрэгтэй байх.

Харин юу гэвэл "сакрамент" гэдэг үгийг олон Протестант урсгалууд Эзэний зоог болон баптисмын тухай ярихдаа ашигласаар ирсэн түүхтэй. Энэ хоёр ёслол бол Бурханаас чуулганд итгэлээ илэрхийлж, ерөөлийг нь авах арга хэрэгсэл болгон өгсөн онцгой бөгөөд ариун ёслолууд юм. Протестант уламжлалуудад эдгээр ёслолуудыг үйлдэх тал дээр бага зэрэг ялгаанууд бий. Гэвч эдгээр ёслолыг онцгой гэдгийг тэд бүгдээрээ хүлээн зөвшөөрдөг.

Заримдаа Христитгэгчид Эзэний зоог болон баптисмыг уучлалд хүрэх арга зам гэхийг сонсоод ихэд сэжигтэй ханддаг. Тиймээс эдгээр ёслолууд нь дангаараа үр дүнд хүрэх ямар ч ач холбогдолгүй гэдгийг онцлон хэлэх нь чухал юм. Эдгээр нь уучлалын үндэс суурь биш.

Гэвч мөн бид Эзэний зоог болон баптисмаар дамжуулан итгэлээ илэрхийлэх үед Ариун Сүнс эдгээр ёслолуудыг ашиглан бидний амьдралд уучлалыг авчирдаг гэж Библид заасан байдаг.

Марк 1:4, Үйлс 2:38, Ром 6:1-7, мөн Колоссай 2:12-14 зэрэг эшлэлүүдэд баптисмыг нигүүлслийн арга зам гэж заасан байдаг.

Нэг жишээ болгож Үйлс 22:16-р эшлэлд Ананиагийн Паулд хэлсэн үгийг сонсоцгооё. Энд:

"Одоо чи юунд саатна вэ? Бос, Түүний нэрийг дуудаж, баптисм хүрт, нүглээ угааж хая" гэв (Үйлс 22:16).

Ананиа энэ заавраараа Паулын гэм нүгэл баптисмаар дамжин уучлагдаж, "угаагдана" гэж тодорхой хэлсэн байна.

Мэдээж баптисм бол уучлалыг авахад заавал шаардагдах арга зам биш ээ. Бид өөр арга замуудаар уучлагдаж болно. Жишээ нь, Есүсийн хажууд хамт цовдлогдож байхдаа итгэсэн нэгэн хулгайч хэзээ ч баптисм хүртээгүй. Гэсэн ч Лук 23:43-р эшлэлд түүнийг уучлагдаж, аврагдсан гэдгийг тодорхой хэлсэн байдаг. Тиймээс бид зөвхөн баптисм хүртсэн хүмүүс л уучлагдаж, авралд хүрнэ гэж буруу ойлгож болохгүй. Гэхдээ Библид баптисмыг бидний амьдралд уучлалыг авчирдаг арга хэрэгслийн үүргийг гүйцэтгэдэг гэдгийг тодорхой зааж өгсөн юм.

Эзэний зоог ч мөн адил. Эзэний зоогийн ёслолд оролцох нь уучлал зэрэг Христийн үхлийн ач тусыг хүлээн авах арга зам мөн гэдгийг Паул тодорхой зааж өгсөн. 1 Коринт 10:16-р эшлэлд энэ тухай өгүүлдэг. Энд:

"Бидний ерөөдөг ерөөлийн аяга нь Христийн цусан доторх оролцоо биш үү? Бидний хугачдаг талх нь Христийн бие доторх оролцоо биш үү?" гэжээ (1 Коринт 10:16).

Энэ бол уран яруу асуултууд юм. Паулын захидлыг уншиж байгаа хүн бүр хариулт нь "Мэдээж, тийм шүү дээ" гэдгийг мэдэж байсан. Итгэлээрээ Эзэний зоогт оролцсоноор бид Христтэй нэгддэг.

Гэм нүглийн уучлал бол бид Христитгэлийнхээ амьдралын туршид үр шимийг нь хүртэх авралын агуу ерөөл юм. Бид дөнгөж итгэсэн, эсвэл он удаан жил итгэсэн аль нь ч бай уучлал бол бидний Христтэй хамт алхах алхааны маань салшгүй хэсэг мөн. Энэ нь мөн өөр олон ерөөлүүдийг авчирдаг.

1791 оны хооронд амьдарч байсан Методист чуулганы үндэслэгч Жон Весли уулан дээрх сургаалыг тайлбарласан 26-р номлолдоо уучлалын тухай заасан байдаг. Тэрээр энд:

Бид нүглийн уучлалыг хүлээн авмагцаа...Түүн дотор итгэлээрээ ариусгагдсан хүмүүсийн нэгэн адил маш ихийг хүлээн авдаг. Гэм нүгэл хүчгүй болсон. Нигүүлслийн дор, Бурханы таалалд байгаа хүнийг нүгэл захирах боломжгүй болсон. Христ Есүс дотор байгаа тэдэнд одоо ямар ч ял байхгүй тул тэд гэм нүглээс ч, буруутгалаас ч чөлөөлөгдсөн. Хуулийн зөвтгөл тэдний дотор гүйцэлдсэнээр тэд махбодын дагуу бус Сүнсний дагуу алхах болсон юм.

Гэм нүглийн уучлал бол зарим талаараа Христитгэгч бидний хувьд хамгийн үнэ цэнтэй бодит үнэн юм. Бидний гэм нүгэл уучлагдсан гэдэг нь Бурхантай буюу Бүтээгчтэйгээ зөв харилцаатай болсныг хэлдэг. Өнөөгийн дэлхий ертөнцийг ажаад байхад хүмүүс утга учрыг, зорилгыг эрэн хайж байгааг бид олж хардаг. Нийгэмд олон төөрөгдөл бий. Амьдрал бүхэлдээ юуны төлөө юм бэ? Бидний амьдарч байгаагийн учир шалтгаан юу юм бэ? Би яагаад энд байгаа юм бэ? гээд л.. Хүмүүс энэхүү утга учир, зорилгыг олохын төлөө ажил төрөл, бэлгийн харилцаа, мансууруулах бодис гээд бүхий л зүйлсийг туршиж үздэг. Өөрөөр хэлбэл хүмүүс аз жаргал, баяр хөөрийг олохын тулд замнадаг олон төрлийн зам харгүй бий. Харин Сайнмэдээ нь хүний үндсэн хэрэгцээ бол биднийг бүтээсэн Бүтээгчтэйгээ зөв харилцаатай байх гэдгийг хэлж өгдөг. Мөн Бурхан Өөрийн Хүү, Есүс Христийг илгээж, бидний нүглийг цагаатгаснаар Бурханы уур хилэнг намжаасан гэдгийг бид Сайнмэдээнээс л олж мэддэг. Бурхан хайрынхаа улмаас Хүүгээ илгээсэн тул бидний гэм нүгэл уучлагдах боломжтой болсон. Тиймээс л хэрэв бид Түүнд итгэвэл гэм нүгэл маань уучлагддаг юм. Бид ийнхүү уучлагдан, Христ рүү эргэх үед энэ дэлхийд бид ер бусын амар тайван, зөвт байдлыг мэдэрдэг. Учир нь энэ бол дэлхий дээрх жинхэнэ зөвт байдал байдаг. Тэгээд бид гэнэтхэн л чухам юуны төлөө бүтээгдсэнээ ухаардаг. Бид Бурхантай зөв харилцаатай байхаар бүтээгдсэнээ яг тэр мөчид ойлгож мэддэг.

-Др. Томас Р. Шрайнер

Ингээд бүгдээрээ гэм нүглийн уучлалын талаарх онол сургаалыг судаллаа. Одоо тэгэхээр итгэлийн дараагийн сэдэв болох биеийн амиллын тухай үзэхэд бэлэн боллоо.

АМИЛАЛ

Элч нарын тунхгийн үгийг эргэн санацгаая:

Би...

биеийн дахин амилалд... итгэдэг.

Элч нарын тунхгийн энэ хэсэгт Есүсийг амилах тухай хэлээгүй гэдгийг бид тодорхой болгох хэрэгтэй. Есүс тунхаг бий болохоос өмнө үхлээс аль хэдийн амилсан байсан тул тунхагт Түүнийг гурав дахь өдрөө үхлээс амилсан гэж хэлсэн байдаг. Харин Элч нарын тунхагт хэлсэн "биеийн амилал" нь бүх нийтийн амилал буюу Христ алдар дотроо эргэн ирэхэд бүх хүн амилах амиллын тухай юм.

Бид биеийн бүх нийтийн амиллын тухай гурван алхмаар авч үзэх болно. Нэгдүгээрт, бидний биеийг үхэлд хүргэдэг хараалын тухай үзнэ. Хоёрдугаарт, Христигтэлийн Сайнмэдээ нь биеийн амиллын тухай өгүүлдэг болохыг судална. Гуравдугаарт, бидний бие эцэст нь хэрхэн аврал чөлөөлөлтийг олох тухай үзэх болно. Ингээд бүгдээрээ бидний биеийг гарцаагүй үхэлд хүргэдэг тэрхүү хараалын тухай эхлээд үзэцгээе.

ХАРААЛ

Өмнөх хичээлүүдээр үзсэнчлэн Бурхан хүнийг бие махбод болон сүнснээс бүрдэж байхаар бүтээсэн. Еврей 4:12, 1 Тессалоник 5:23-р эшлэлүүдэд үндэслэн хүн бүрд сүнс ба сэтгэл бий гэж үздэг уламжлалууд ч бий. Гэхдээ Библид энэ хоёр үгний аль нэгийг ашиглан хүний дотоод буюу бие махбодын бус мөн чанарыг бүхэлд нь илэрхийлсэн 200 орчим эшлэлүүд байдаг. Тиймээс ихэнх Христигтэлийн уламжлалууд "сүнс" болон "сэтгэл" гэдэг хоёр үг хоёулаа хүмүүн нь бие махбод ба сүнс гэсэн хоёр үндсэн хэсгээс бүтсэн гэдэг нэг л бодит үнэнийг илэрхийлж байна хэмээн дүгнэсэн байдаг.

Гэм нүгэлд унахаасаа өмнө хүмүүний бие махбод болон сүнс гэм нүглийн хүчний нөлөөнд ороогүй, завхралд автаагүй байсан. Харин Адам Ева хоёр нүгэл үйлдсэний дараа нүгэл тэдний сүнсийг төдийгүй бие махбодыг нь ч мөн сүйтгэсэн юм. Тэдний бие махбодод учирсан тэрхүү завхрал нь эцэстээ үхэлд хүргэсэн. Бурхан Адамыг хараасан тухай Эхлэл 3:19-д өгүүлдэг. Энд:

"Чи газар шороондоо буцталаа духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж иднэ. Учир нь чамайг хөрс шорооноос авсан. Чи хөрс шороо тул хөрс шороондоо буцна" гэжээ (Эхлэл 3:19).

Адам Ева хоёр Бурханы эсрэг нүгэл үйлдэхэд Бурхан тэднийг хараасан. Тэр хараалаас болж тэдэнд учирсан гарз хохирол бол мөнх амиа алдсан хэрэг байв. Тэд эцэст нь үхэж, газар шороондоо буцах болсон. Бүх хүн төрөлхтөн Адам Ева хоёрын үр удам тул энэхүү хараалыг өвлөн төрдөг. Энэ тухай Паул Ром 5:12-р эшлэлд өгүүлдэг. Тэрээр энд:

"Нэг хүнээр ертөнцөд нүгэл, нүглээр үхэл орж ирсэн бөгөөд бүгд нүгэл үйлдсэн тул бүх хүнд үхэл иржээ" гэсэн байна (Ром 5:12).

Гэм нүгэл Адам Ева хоёрын сүнс ба бие махбодод нөлөөлсөн. Бид тэдний үр удам учраас тэдний хараалыг ч өвлөсөн байх нь. Библид дурдсанчлан бид энэ дэлхийд мэндлэхдээ л сүнсээр үхмэл байдаг. Бид бүгд Бурханы шүүлтийн дор байдаг бөгөөд Бурханд таалагдах бүхий л чадвараа алдсан. Бид энэ тухай Ром 5:12-19, мөн 8:1-8-р эшлэлүүдээс уншиж болно.

Адам Ева хоёрын адил бидний бие махбод ч нүглийн улмаас завхарсан. Энэхүү завхрал нь бие махбодын өвчин зовлон ба үхлийг авчирдаг. Паул Ром 6:12-19-р, мөн 7:4-25-

р эшлэлүүдэд үүний тухай бичсэн байдаг. Гэм нүгэл нь биднийг бүхэлд нь буюу бие махбод, сүнсийг маань сүйтгэж завхруулсан. Харин Бурханы гайхамшигт амлалтад Христийн доторх аврал бидний сүнс ба бие махбодыг аварч чөлөөлнө гэсэн юм.

Христитгэгчид хүний үхлийг энгийн байдаг л зүйл гэж үзэж болохгүй. Бид ихэнхдээ үгээрээ иймэрхүү санаатай зүйлс ярьдаг шүү дээ. Заримдаа оршуулга дээр бид нас барсан хүний тухай "Тэр сайхан урт насаллаа" гэж хэлдэг. Харин үнэхээр хэн нэгэн нь хүүхэд байхдаа эсвэл хорин хэдхэн насандаа нас барсан байвал "Өө, үнэхээр харамсалтай хэрэг боллоо" гэдэг. Үгүй ээ, энэ бол хүний үхлийн талаарх жинхэнэ Христитгэлт үзэл биш. Христитгэлт үзлээр бол хүний үхэл нь хэвийн зүйл биш юм. Бид анхнаасаа үүрд мөнх амьдрахаар бүтээгдсэн. Бүтээлийн үеийн долоо дахь өдрөө Бурхан амарсан тухай бодож үзье л дээ. Тэр бүтээсэн зүйлсдээ үнэхээр сэтгэл хангалуун байсан. Бид Түүний алдрыг өвлөн, бүтээлийн ажлыг нь үргэлжлүүлэх ёстой байсан. Бид хэзээ ч үхэхийн төлөө бүтээгдээгүй юм шүү дээ. Гэтэл Эхлэл номын 2, 3-р бүлэгт мөн Паулын хэлснээр нүглийн хөлс бол үхэл буюу энэ дэлхийд нүгэл орж ирснээр л бид үхдэг болсон юм. Тэр үхэл нь бие махбодын үхэл бас сүнсний үхэл байсан.

-Др. Стефен Ж. Веллум

Зарим талаараа Христийн оршихуйд шууд очих учраас бие махбодын үхэл нь итгэгчдийн хувьд ерөөл гэлтэй. Гэхдээ уг үндсийг нь харах юм бол бие махбодын үхэл бол эмгэнэлтэй хэрэг мөн. Энэ нь хүн төрөлхтний жам болсон хэдий ч, үнэндээ байх ёсгүй, аймшигт зүйл. Бурхан хүнийг үхүүлэхийн төлөө бус амьдруулахын төлөө бүтээсэн. Тиймээс бидний аврал Христ эргэн ирж, бие махбодыг маань золихоос нааш бүрэн гүйцэд болохгүй.

Бид бие махбодыг үхэлд хүргэдэг хараалын тухай үзлээ. Харин одоо Сайнмэдээ нь хэрхэн амиллыг заадаг тухай ярилцацгаая.

САЙНМЭДЭЭ

Тэнгэрийн улсад бие махбодгүй болсон сүнсээрээ үүрд мөнх байна гэж итгэдэг хэчнээн Христитгэгчдийг та нар мэдэх вэ? Тийм ч цөөхөн биш байх. Хэдийгээр хачирхалтай сонсогдож байж магадгүй ч зарим орчин цагийн чуулганууд үхэгсдийн амиллын талаарх онол сургаалыг огт мэддэггүй. Үүний нэг шалтгаан нь Христитгэгчид хүний бие махбод ямар чухал болохыг сайн ойлгож чаддаггүйд байдаг. Харин Христ эргэн ирэхэд бидний сүнс төдийгүй бие маань ч мөн алдаршуулагдах болно гэдэг Сайнмэдээг Бичвэр тун тодорхой заадаг.

Бид биеийн амилал бол Сайнмэдээний нэг хэсэг гэдэг ойлголтыг судлахдаа бид гурван асуудлыг хөндөх болно. Нэгдүгээрт, бид энэхүү онол сургаалын тухай Хуучин Гэрээнд юу гэж заасныг үзнэ. Хоёрдугаарт, энэ тухай Шинэ Гэрээнд тун тодорхой тунхагласан байдаг тухай харна. Гуравдугаарт, бид итгэгчид ба Есүсийн амиллын хоорондын холбоог судлах болно. Ингээд Хуучин Гэрээнээс эхэлцгээе.

Хуучин Гэрээ

Сайнмэдээ гэдэг үг үнэндээ Хуучин Гэрээнээс гаралтай болохыг орчин цагийн Христитгэгчид ихэнхдээ анзаардаггүй байх л даа. Ялангуяа Исаиа 52:7, 61:1, мөн Нахум 1:15 зэрэг эшлэлүүдээс энэ тухай харж болно. Исаиа 52:7-р эшлэлийг жишээ болгон сонсоцгооё. Энд:

"Амар тайвныг сонордуулж, сайн сайхныг мэдээлж, авралыг сонсгож, Сионд хандан "Чиний Бурхан хаанчлах нь ээ" гэж хэлэх Сайнмэдээ авчрагчийн хөл уулсын дээр юутай үзэсгэлэнтэй вэ?" гэжээ (Исаиа 52:7).

Хуучин Гэрээнд, "авралын зар" буюу "сайн мэдээ" гэдэг нь Бурхан Өөрийн болон ард түмнийхээ дайсныг дарж тэднийг аварна гэсэн утгатай байсан. Явцуу утгаараа энэ нь Бурхан Өөрийн ард түмнийг газар дэлхий дээрх дайсных нь дарлалаас аварна гэсэн Сайнмэдээ юм. Харин өргөн утгаараа энэ бол Бурхан адам Ева хоёр нүгэлд унаснаас болж үүссэн бүх хараалыг устгана гэсэн Сайнмэдээ билээ. Тэрээр сүр жавхлант бурханлаг хаанчлалаа бүх дэлхийд тогтоож, Өөрт нь итгэдэг хүн бүрийг ерөөнө гэсэн үг.

Мэдээж Хуучин Гэрээнд Бурханы үзүүлж байсан аврал нь Христийн ирээдүйн ялалтад тулгуурлаж байсан. Христ хараахан гэм нүглээс болж үхээгүй байсан ч Өөрийн хүмүүсийн өмнөөс амиа өгөх амлалтыг аль хэдийн өгсөн байсан. Энэхүү амлалт нь тэдний авралд хангалттай баталгаа болсон юм. Үнэндээ Хуучин Гэрээн дэх авралын найдвар бүр Христ рүү болон Түүний гүйцэлдүүлэх зүйл рүү чиглүүлсэн байдаг.

Еврей 10:1-5-р эшлэлд Хуучин Гэрээний тахилуудыг юу гэж тайлбарласныг сонсоцгооё. Энд:

"Учир нь хуульд ирэх сайн юмсын жинхэнэ дүр нь бус, харин сүүдэр нь байдаг... Яагаад гэвэл бух, ямааны цусаар нүглийг авч хаях боломжгүй юм. Тиймээс Тэр ертөнцөд ирэхдээ "Та өргөл ба тахилыг хүсээгүй, Харин Та Надад бие бэлдсэн" гэжээ (Евре 10:1-5).

Хуучин Гэрээний тахилууд нь хожим Христийн дотор бодитоор биелэх зүйлсийн сүүдэр төдий байсан гэдгийг Еврей номын бичээч тодорхой хэлсэн байна. Бурхан хүмүүний нүглийн шийтгэлд хүмүүний үхлийг шаарддаг тул амьтдын өргөл тахил хэзээ ч нүглийг бүрэн төгс цагаатгаж чадахгүй байв. Гэвч тэдгээр нь Есүс рүү зааж чадах бөгөөд зааж ч байсан юм. Төгс хүмүүн болох Есүсийн үхэл нь нүглийг цагаатгахад бүрэн дүүрэн, хангалттай байсан.

Бурхан бүх үхсэн хүмүүсийг амилуулж, хийсэн үйл бүрээр нь шүүх өдөр ирнэ хэмээн Бурханы хүмүүст зааж байсан нь Хуучин Гэрээний Сайнмэдээний салшгүй хэсэг байсан. Бурханд итгэж, зөвт амьдарсан хүмүүс үүрд мөнхийн ерөөлийг хүртэнэ. Харин Бурханы эсрэг тэрслэгсэд нь үүрд мөнхөд шийтгэгдэх болно. Энэ хоёр үр дагаврыг хүн бие махбодоороо үүрд мөнхөд эдлэх юм. Христитгэлийн теологичид энэ үйл явдлыг эцсийн шүүлт гэж ихэнхдээ тодорхойлдог.

Өмнөх хичээлээр үзсэнчлэн Элч нарын тунхагт эцсийн шүүлтийн тухай өгүүлсэн байдаг. Энд:

"Тэндээс үхсэн, амьд Бүх хүнийг шүүхээр ирэх..." гэжээ.

Энэ ойлголтын тухай хамгийн тодорхой тайлбар бол Даниел 12-р бүлэг дэх биеийн амиллын тухай өгүүлэх эцсийн шүүлтийн талаарх тайлбар байж болох юм. Бурхан ирээдүйд Өөрийн хүмүүсийг дарамтаас чөлөөлнө хэмээн тэнгэрэлч Даниелд илчилсэн байдаг.

Даниел 12:1-2-р эшлэлд Даниелд юу гэж хэлснийг сонсоцгооё. Энд:

"Тэр үед ард түмний чинь дундаас номд бичигдсэн бүгд аврагдах болно. Газар шороонд нойрсогч олон хүн сэрж, зарим нь мөнх амь руу бусад нь гутамшиг ба мөнхийн жигшил руу явна" гэжээ (Даниел 12:1-2).

Даниел газар шороонд нойрсогч нарын тухай ярихдаа биеийн амиллын тухай онцгойлон хэлсэн юм. Газар шороонд сүнс биш бие махбод маань нойрсдог. Тэгэхээр энд эцсийн шүүлтийн үед бие махбод амилах тухай хэлсэн байх нь.

Исаиа ч мөн адил шүүлтийн өдрийн тухай ярихдаа амилалтай холбон ярьсан байдаг. Энэ тухай Исаиа 26:19-21-р эшлэлд дурдсан байдаг. Энд:

"Таны үхэгсэд амилж, цогцос нь босно. Шороонд хэвтэгчид ээ! Бос, баярлан хашхирагтун...Газар нь үхэгсдийг гаргана... Учир нь ЭЗЭН дэлхийн оршин суугчдыг хилэнцийнх нь төлөө шийтгэхээр Өөрийнхөө газраас ирэх гэж байна..." гэжээ (Исаиа 26:19-21).

Энэ эшлэлд бас газар шороон дор байгаа үхэгсэд яг л газар тэднийг төрүүлж байгаа мэтээр булшнаасаа амилж, шинэ амьдралтай болно гэсэн байна. Гэхдээ энэ үйл явдал шүүлтийн үед Эзэн дэлхий дээрх хүмүүсийг нүглийнх нь улмаас шийтгэхээр ирэхэд болно гэжээ.

Үхэгсдийн амиллын тухай онол сургаал нь эцсийн шүүлт ба шийтгэлийн өдөр Шеолоос аврагдах тухай бичсэн Хуучин Гэрээний цөөнгүй эшлэлүүдэд тусгалаа олсон байдаг. Тухайлбал, энэ тухай Дуулал 49:7-15, мөн Дуулал 73:24-28 зэрэг хэсэгт бий. Мөн Иов шүүлтийн тэрхүү өдөр буюу газар дэлхий дээр ирэх Эзэний өдөр Бурханыг харахаар амилах болно гэдгээ Иов 19:25-27-д итгэл төгс илэрхийлсэн байдаг.

Хуучин Гэрээнд ирээдүйн амилал ба шүүлтийн талаар мэдээж Шинэ Гэрээ шиг тодорхой байдаггүй л дээ. Гэвч Хуучин Гэрээнд энэ үйл явдал болох тухай тодорхой зүйлс бий. Жишээ нь, Исаиа үхсэн хүмүүс амь орж, булшнаасаа гарч ирэх тухай хэлсэн байдаг. Даниел ч мөн үүний адил үхэгсэд гарч ирэн, зөвт ба хорон муу хүмүүс шүүгдэх өдрийн тухай өгүүлдэг. Тиймээс энэ итгэл үнэмшил нь бүх Иудейчүүдийн дунд биш ч, заримынх нь дунд тархсан байсан. Есүсийн үеийн Фарисайчууд амилалд итгэдэг байв. Харин Садукайчууд итгэдэггүй байсан. Тиймээс Садукайчууд ирж энэ талаар Есүсээс асуусан байдаг. Ингэхдээ тэд Түүнийг тохуурхан, зальжин асуулт асуусан. Тэгэхэд нь Есүс Бурханы хэлсэн үгээс эш татан "Би бол Абрахамын Бурхан, Исаакийн Бурхан, Иаковын Бурхан" гэж хэлээд, "Бурхан бол үхэгсдийн бус, харин амьд хүмүүсийн Бурхан" гэж хариулсан байдаг. Тэгэхээр Бурхан Абрахамтай гэрээ байгуулахдаа, ер нь хэн нэгэнтэй харилцаа тогтоож, гэрээ байгуулахдаа хувьчлан харилцдаг байсан. Тиймээс хэрэв Абрахам үхээд

газарт булагдан, хэзээ ч амилахгүй юм бол Бурхан Абрахамтай мөнхийн гэрээний харилцаатай болсон гэж хэлэх нь хүртэл утгагүй зүйл болох байсан шүү дээ. Тиймээс Шинэ Гэрээ эргэж буцахгүйгээр амиллын онолыг тууштай баримталсан гэж хэлж болно. Мэдээж Есүсийн амилал нь энэ үнэнийг батлах эцсийн тамгыг дарсан билээ.

-Др. Жон М. Фрэйм

Бүх нийтийн амилал нь Хуучин Гэрээн дэх Сайнмэдээний салшгүй хэсэг байсан гэдгийг бүгдээрээ үзлээ. Харин одоо энэ нь мөн Шинэ Гэрээний Сайнмэдээний нэгэн хэсэг байсан тухай харцгаая.

Шинэ Гэрээ

Хуучин болон Шинэ Гэрээний Сайнмэдээний тунхаглалын хамгийн гол ялгаа нь Шинэ Гэрээнд Аврагч эцэст нь ирсэн явдал юм. Тэрээр эцэст нь Назарын Есүс болон түүхэнд илчлэгдсэн. Бурхан энэ үеэс эхлэн Хүү Есүсээр дамжуулан хаанчилсан. Шинэ Гэрээнд Есүс бол Эзэн, өөрөөр хэлбэл Түүнийг хаанчилж буй Хаан гэдгийг маш олон удаа онцолсон нь ийм учиртай. Бид энэ тухай Лук 2:11, Үйлс 2:36, Ром 10:9, мөн 1 Коринт 12:3 зэрэг эшлэлүүдээс харж болно.

Аврал нь Хуучин ба Шинэ Гэрээнд Бурханы амлалтад итгэх итгэлээр л ирдэг. Хуучин ба Шинэ Гэрээний итгэлийн гол ялгаа нь юу гэвэл энэ нь Бурханд итгэх итгэлийн тухай байдаггүй, харин хамгийн гол нь ямар амлалтад итгэж байгаа гэдэгт байсан юм. Хуучин Гэрээний итгэл нь хараахан биелээгүй байгаа амлалтыг биелнэ гэж хүлээж байсан. Харин Шинэ Гэрээний итгэл нь загалмай руу буюу аль хэдийн биелсэн амлалт өөд харж, итгэх явдал байдаг. Тиймээс энэ хоёр гэрээ хоёулаа Бурханы биелүүлэх, бидний гүйцэлдүүлж чадахгүй тэрхүү төлөвлөгөөнд итгэн, Бурхан руу хандах итгэлийн тухай байдаг гэсэн үг юм.

-Др. Роберт Г. Листер

Есүсийн дотор Хуучин Гэрээний авралын бүхий л амлалт биелсэн. Еврей 10:1-5-р эшлэлээс бид Түүний үхэл бол Хуучин Гэрээний тахилуудын жинхэнэ биелэл байсныг хардаг. Мөн Есүсийн Сайнмэдээ нь Хуучин Гэрээний эцгүүдэд өгсөн амлалтын биелэл байсан гэдгийг Ром 15:8-13, Галат 3:16 дээр заасан байдаг. Эдгээр болон бусад олон арга замаар Шинэ Гэрээ нь Хуучин Гэрээний Сайнмэдээг баталж өгдөг бөгөөд энэ нь тэнгэрлэг хаан эцэст нь итгэлээр дамжуулан нигүүлслээрээ ард түмэндээ авралыг авчрахаар ирсэн тухай Сайнмэдээ юм.

Бүх нийтийн амилал эцсийн шүүлтийн үед болно гэж Есүс айлдсан. Тухайлбал, Матай 22:23-32, Лук 20:27-38 дээр Есүс амиллын тухай үгүйсгэдэг Садукайчуудын үзэл бодлыг нь няцаасан байдаг. Лук 14:13-14 дээр Есүс итгэгчдийг амилалд шагнагдах болно гэсэн үндсэн дээр сайн үйлс хийхийг урамшуулсан байдаг. Мөн Иохан 11:24-26-р эшлэлд Тэрээр Лазарын дүү Мартатай ярихдаа энэ сургаалаа баталсан. Лук 20:37-р эшлэлд Есүс юу гэж хэлснийг сонсоцгооё. Тэрээр энд:

"Харин Мосе шатаж буй бутны тухай хүүрнэлдээ ... үхэгсэд амилахыг харуулсан юм" гэжээ (Лук 20:37).

Энэ эшлэлд Есүс үхэгсдийн амилал нь Хуучин Гэрээнд аль хэдийн илчлэгдсэн гэдгийг нотолсон байна. Энэ санааг Шинэ Гэрээний бусад бүхий л хэсгүүд баталсан байдаг. Гэвч олон олон чуулганууд үхэгсдийн амиллыг орхигдуулсаар байдаг нь харамсалтай. Бие махбодгүй сүнсээрээ үүрд мөнхөд байна гэж итгэдэг итгэгчид олон байх болжээ. Харин Еврей 6:1-2-р эшлэлд үхэгсдийн амиллыг Христитгэлийн үндсэн гол онол сургаалын нэг гэж тайлбарласан байдаг. Мөн Еврей 11:35-д итгэгчдийн амиллыг сайн үйлс хийх хөшүүрэг болгон ашигласан байдаг. Үнэндээ итгэгчид Хуучин Гэрээний амиллын амлалтуудад итгэдэг байсан тухай элч нар байнга онцолдог байсан. Тухайлбал, Петр, Иохан хоёр энэ тухай онцлон ярьсан талаар Үйлс 4:1-2-т өгүүлдэг. Мөн Паул энэ тухай онцолсныг бид Үйлс 23:6-8 болон 24:14-21-р эшлэлүүдээс харж болно.

Үйлс 24:14-15-р эшлэлд Паул өөрийн үйлчлэлийг хэрхэн өмгөөлснийг жишээ болгон харцгаая. Тэрээр энд:

"Харин үнэндээ энэ хүмүүсийн бүлэглэл гэж нэрлээд байгаа тэр Замын дагуу би эцэг өвгөдийнхөө Бурханд үйлчилдэг нь үнэн. Хууль болон Эш үзүүлэгчдийн бичсэн бүгдэд итгэдгээ би хүлээн зөвшөөрнө. Тэдний найддагийн адилаар зөвт ба зөвт бус хэн хэн нь амилна гэдэгт би ч Бурханд найддаг" гэжээ (Үйлс 24:14-15).

Энэ эшлэлд Паул эцсийн шүүлтийн үеийн бүх нийтийн амиллын талаарх Христитгэлийн найдвар нь Иудейн итгэл найдвартай яв цав адилхан гэдгийг онцолжээ. Харин ялгаа нь гэвэл энэхүү амилал гагцхүү Христээр дамжин биелэгдэнэ гэдэгт Христитгэгчид итгэж байсанд оршдог.

Бид Бурханы авралын төлөвлөгөө нь үргэлж нэгэн хэвээр байсан гэдгийг ойлгох нь чухал. Тэр эртний Израилчуудад аврагдах нэг арга зам зааж өгчхөөд бидэнд бас нэг өөр арга зам зааж өгсөн гэсэн үг биш юм. Эсвэл Тэрээр Иудейчүүдэд өгсөн авралын арга замаасаа өөр арга замыг харь хүмүүст өгсөн гэсэн үг ч биш ээ. Хуучин болон Шинэ Гэрээний сургаал нь нэгдмэл байдаг. Тиймээс ч Христитгэгчид Хуучин Гэрээг амьдралд нь зориулсан Бурханы үг хэмээн эрхэмлэдэг. Бурханы хүмүүс үргэлж нигүүлслээр, итгэлээр дамжуулан, Христийн дотор л аврагдсаар ирсэн. Бурхан Өөрийн итгэмжит хүмүүст үзүүлсээр ирсэн аврал ба өршөөлийн урт удаан түүхийн нэгэн хэсэг нь Христитгэгчид мөн. Библи бүхэлдээ буюу хоёр Гэрээ хоёулаа бидэнд энэ гайхамшигт үнэнийг заадаг.

Ингээд бүгдээрээ Хуучин ба Шинэ Гэрээний Сайнмэдээнд үхэгсдийн амилал буй талаар өгүүлдэг болохыг үзлээ. Одоо харин итгэгчдийн амилал болон Есүсийн амиллын хоорондох уялдаа холбоог авч үзье.

Есүсийн амилал

Шинэ Гэрээн нь Есүсийн амилал болон итгэгчдийн амиллын хооронд дор хаяж хоёр чухал холбоо бий гэдгийг заадаг. Нэгдүгээрт, бид Есүсийн амилалтай нэгдсэн тул онцгой ерөөгдсөн аминд амилах болно. Энэ талаар Паул Ром 6:4-5-р эшлэлд өгүүлсэн байдаг. Энд:

"Бид үхэл рүү баптисм хүртсэнээрээ Түүнтэй хамт оршуулагдсан учраас, Эцэгийн алдраар Христ үхэгсдээс амилуулагдсаны адил, бид мөн шинэ амийн дотор явах юм. Учир нь, хэрэв бид Түүний үхэлтэй адил байдалд холбогдсон юм бол, мэдээж Түүний амилалтай нь ч адил байдалд бас холбогдох болно" гэжээ (Ром 6:4-5).

Итгэлээр дамжуулан баптисм нь биднийг Христийн үхэлтэй нэгтгэснээр бидний нүглийн өр төлөгддөг хэмээн Паул заасан байна. Энэ нь мөн биднийг Түүний амилалтай холбодог. Ингэснээр одоо буй амьдралд сүнс минь шинэчлэгдэн, ирээдүйд бие махбод маань амилах билээ. Есүсийн амилалтай нэгдсэн бидний нэгдлийн тухай 1 Коринт 15:21-22, Филиппой 3:10-12, мөн Колоссай 2:12 зэрэг эшлэлүүдэд заасан байдаг.

Бид Есүсийн амилалтай нэгдсэн учраас бидний амилал ч мөн баталгаажсан. Энэ тухай 1 Коринт 15:20-23-р эшлэлд Паул юу гэж бичсэнийг сонсоцгооё. Тэрээр энд:

"Гэвч Христ үхэгсдээс амилуулагдсан бөгөөд нойрсогсдын анхны үр жимс мөн. Учир нь үхэл нэг хүнээр ирсэн тул үхэгсдийн амилал мөн нэг хүнээр иржээ...Харин тус бүр өөрийн дараалалтай байна. Христ бол анхны үр жимс, дараа нь Түүнийг ирэхэд Христийнхэн амилуулагдана" гэжээ (1 Коринт 15:20-23).

Энэ эшлэлд Паул Есүсийн амиллыг Түүнд хамаатай бүхий л хүнийг хамруулсан ургацын анхны үр жимс гэж тодорхойлсон байна.

Хуучин Гэрээнд Бурхан Израилчуудыг ургацынхаа дээжийг Өөрт нь өргөхийг шаардсан байдаг. Бид энэ талаарх жишээг Левит 23:17 дээрээс харж болно. Ургацын дээж гэдэг бол бүх ургацын хамгийн анхны үр жимс ба бүх ургацын төлөөлөл юм. Израилчууд ургацынхаа дээжийг ийнхүү Эзэнд өргөдөг байсан нь тэд өөрсдөө ургацын үлдсэн хэсгийг хүлээн авна гэдэг итгэлийнх нь баталгаа байлаа. Бурхан Есүсийн амиллыг боломжтой болгосноороо биднийг ч тийнхүү амилуулах хүслээ харуулсан. Тиймээс итгэгч хүний хувьд бид Христийн амиллаар Бурхан биднийг тэрхүү өдөр тамгалсан гэдгийг мэдсэнээр ирээдүйн амилалдаа итгэлтэй байж чадах юм.

Биеийн амиллын тухай үзэхдээ бидний биеийг үхэлд хүргэдэг хараалын тухай үзсэн. Мөн Сайнмэдээ нь биеийн амиллын тухай заадаг болохыг судалсан. Харин одоо бидний бие аврал золилтыг чухам хэрхэн амсах тухай харцгаая.

ЗОЛИЛТ

Бид биеийн золилтыг гурван үе шатанд хуваан үзэх болно. Нэгдүгээрт, итгэгчдийн газар дэлхий дээрх энэ амьдралдаа амсаж туулах зүйлсийн тухай. Хоёрдугаарт, бидний бие үхсэний дараа амилах хүртэлх завсрын үеийн тухай. Гуравдугаарт, Христ эргэн ирэх үед эхлэх амиллын шинэ амьдралын тухай тус тус үзэцгээе. Ингээд одоо бүгдээрээ одоогийн амьдралынхаа тухай эхлээд суралцацгаая.

Одоогийн амьдрал

Христитгэгчид биеийн золилтыг эцсийн өдрийн амилалтай холбон ярьдаг. Гэвч чухамдаа Библид бидний биеийн аврал нь анх итгэсэн мөчид Ариун Сүнснийг хүлээн авснаар

эхэлдэг гэж заадаг. Ариун Сүнс бидний дотор орших тухай Ром 8:9-11-р эшлэлд дурдсан байдаг. Хэдийгээр энэ нь мэдээж бидний бие тэр даруй амилна гэсэн үг биш ч гэсэн ирээдүйд бүрэн золигдоно гэдгийг маань батлан тамгалдаг юм. Энэ тухай Паул Ефес 1:13-14-р эшлэлд заасан байдаг.

Гэхдээ бидний бие насан туршдаа дотор минь оршин буй Ариун Сүнсний оршихуйн ач тусыг амсаж мэдрэх болно. Ялангуяа ариушлаар дамжуулан бид ийнхүү амсдаг. Бидний биеийн ариусал сүнсний ариусалтай адил байдаг. Ариун Сүнс биднийг Бурханд зориулан тусгаарлаж, ариусгадаг. Тэр биднийг амьдралын маань туршид ариусгаж, биеэр үйлдсэн нүглийг маань уучилдаг бөгөөд өөрсдийн биеэр Эзэнийг хүндэлдэг гэдгийг баталж байдаг. Ийнхүү бид Паул 1 Коринт 6:20-р эшлэлд заасанчлан биеэрээ Бурханыг алдаршуулж, Ром 12:1-р эшлэлд бичсэнээр Бурханд өөрсдийн биеийг амьд ариун тахил болгон өргөдөг.

Завсрын үе

Итгэгчдийн одоогийн амьдрал дахь биеийн золилт эхэлсний дараа энэхүү үйл явц нь биеийн үхлээр үргэлжилдэг. Үхэх үед бидний бие сүнснээсээ түр тусгаарлагддаг. Энэ үе шатыг ихэвчлэн завсрын үе гэж нэрлэдэг. Энэ нь газар дэлхий дээрх амьдрал болон амилал дахь амьдралын хоорондох үе гэсэн үг. Завсрын үе шатанд бидний сүнс тэнгэрт Христтэй хамт орших болно. Библид энэ тухай Матай 17:3, 2 Коринт 5:6-8 зэрэг эшлэлүүдэд бичсэн байдаг.

Гэвч бидний сүнс тэнгэрт байх бол бие маань газарт байна. Бие махбод маань ялзарч муудаж буй нь нүглээс болж завхарсан хэвээр байгааг нотолно. Гэхдээ нүгэл биеийг маань ялзруулах хэдий ч нүгэл үйлдүүлэх нөлөөгүй болсон байна. Нэг талаар Ром 6:2-11 эшлэлд Паулын зааснаар үхэл биднийг нүглийн ноёрхлоос чөлөөлдөг гэсэн үг. Харин нөгөө талаар, бие маань булшиндаа амьгүй хэвтэн, сайн мууг алиныг ч бодож сэтгэх, үйлдэх, мэдрэх чадваргүй байх болно.

Хэдийгээр үхэх үед бидний бие болон сүнс түр зуур тусгаарлагдсан ч бидний бие бидний нэг хэсэг байхаа болино гэж Библид огт хэлээгүй. Тэднийг оршуулсан ч бай, чандарласан ч бай, алга болсон ч бай бидний бие бидний нэг хэсэг хэвээр байна. Энэ талаарх олон жишээг бид Библиэс харж болно. Тухайлбал, 1 Самуел 25:1 дээр Самуелыг Рама дахь гэрт нь оршуулсан гэсэн байдаг. 1 Хаад 2:10-д Давидыг Давидын хот Иерусалимд оршууллаа гэдэг. 1, 2 Хаад, мөн 2 Шастир зэрэг номуудаар дүүрэн Иудейн хаадыг өвөг Давидынх нь хотод оршуулсан тухай өгүүлдэг. Тэдний бие тэднийх хэвээр бөгөөд биеийнх нь салшгүй хэсэг байсаар байх болно.

Вестминстрийн категизм буюу Товч Асуулт Хариултын 37-р асуулт хариултад үхлийн тухай тайлбарласан байдаг. Асуулт нь:

Итгэгчид үхэх үед Христээс ямар ашиг тусыг хүлээн авах вэ? гэдэг.

Хариулт нь:

"Итгэгчид үхэх үед сүнс нь төгс ариун болж, тэр даруйд сүр жавхланд орох болно. Харин тэдний бие Христтэй нэгдсэн хэвээр байх ба амилал хүртэл булшиндаа нойрсох болно" гэжээ.

Категизм энэ хариултаараа итгэгчид үхэх үед хоёр янзын тавилантай тулгарах болно гэж хэлсэн байна. Нэг нь сүнсний хувьд, нөгөө нь бие хувьд юм. Бидний сүнс тэнгэрийн улсын сүр жавхланд орно. Харин бие маань Христтэй нэгдсэн хэвээр байх ба булшиндаа чимээгүй нойрсон, амилалд шинэ амьдралтай болохоо хүлээх нь байна.

Сүнс маань тэнгэрт, харин бие маань булшинд байна... Тиймээ бид нэгэн зэрэг хоёр газар байх болно гэдэг нь үнэн гэж би боддог. Мэдээж тайлбар хэрэгтэй. Товч категизм буюу асуулт хариултад үүнийг маш сайхан тайлбарлаж өгсөн байдаг. "Итгэгчид үхэх үед сүнс нь төгс ариун болж, тэр даруйд сүр жавхланд орох болно. Харин тэдний бие Христтэй нэгдсэн хэвээр байх ба амилал хүртэл булшиндаа нойрсох болно." Энэ хариултын эхний хэсэгт өгүүлж буй сүнс нь биеэс салах тухай ойлголт нь 2 Коринт 5-р бүлгийн 1-10-р эшлэлийн гол сэдэв юм. Паул өөрийн зуурдын биеийг газар дээрх майхан гэж нэрлээд, сүнс нь биеэсээ салах нь жам ёсных биш тул үхлийг таалдаггүй болохоо хэлсэн байдаг.

-Др. Нокс Чамблин

Нэгэн зэрэг хоёр газарт байхын зовлонг бид тэнгэрт байхдаа ч мэдрэх болно. Тэнгэрийн улс мэдээж бидний төсөөлснөөс ч агуу гайхамшигтай байна гэдэгт эргэлзэх зүйлгүй. Гэвч тэнгэрт очсон хойно ч бидний бие амилаагүй байх тул аврал бүрэн гүйцэд болоогүй байх болно гэдэг нь үнэн юм. Биеийн амиллын тухай Ром 8:23-р эшлэлд Паул юу гэж хэлснийг сонсоцгооё. Тэрээр энд:

"Зөвхөн бүтээл ч биш, Сүнсний анхны үр жимсийг авсан бид ч өөрсдөө бас дотроо ёолж, биднийг үрчилж авахыг буюу биеийг маань золин аврахыг тэсэж ядан хүлээдэг" гэжээ (Ром 8:23).

Энэ эшлэлд Паул бидэнд амилсан бие үгүй тул энэ амьдралдаа бид шаналан ёолдог гэжээ. Гэвч тэнгэрт байгаа сүнснүүд ч мөн шинэ биеэ хүлээсээр байгаа аж. Тэгэхээр зарим талаараа тэд ч бас биеийнхээ золилтыг хүлээн, ёолж байгаа гэсэн утгатай байна.

Зарим хүмүүс бидний хүлээж авах бие нь газар дэлхий дээр байхад л тохиромжтой өмсгөл, зайлшгүй шаардлагагүй хэрэглэл төдий юм гэдэг. Тиймээс бид биегүй байвал илүү дээр, сэтгэл хангалуун байх болно гэж боддог. Энэ нь Библийнхээс арай илүү платоник хийсвэр юм шиг санагддаг. Тэгвэл үхэл ба амиллын хоорондох завсрын энэ үед байх нь чухам ямархуу байх бол? Бидэнд үүний талаар тодорхой зураглал бүхий тайлбар байхгүй. Гэхдээ Библийн өгсөн хариулт нь бидэнд баталгаа өгдөг бөгөөд маш их хамаатай байдаг. Бид Эзэнтэй хамт байх болно.

-Др. Глен Ж. Скоржие

Бид одоогийн амьдрал болон бие махбодын үхлийн тухай үзлээ. Тиймээс бүгдээрээ шинэ амьдралд биеийн золилт хэрхэн бүрэн төгс болох тухай үзэхэд бэлэн болжээ.

Шинэ амь амьдрал

Бидний бие бүх нийтийн амиллаар амилан сэргээгдэх үед бид шинэ, төгс амь амьдралыг хүлээн авах болно. Үхлээс амилах тэр үед гэм нүглийн үр дагавар эцэст нь биднээс үүрд мөнхөд, бүр мөсөн салах болно. Бид энэ тухай Ром 8:23,1 Коринт 15: 12-57, мөн Филиппой 3:11 зэрэг эшлэлүүдээс харж болно. Теологичид авралын энэ үе шатыг ихэвчлэн алдаршуулал гэж нэрлэдэг. Учир нь бид алдаршуулагдсан, төгс хүн болох юм. 1 Коринт 15-р бүлэгт Паул бидний одоогийн биеийг алдаршуулагдсан биетэй харьцуулсан байдаг. 1 Коринт 15:42-44-р эшлэлд түүний юу гэснийг сонсоцгооё. Тэрээр энд:

"Үхэгсдийн амилал нь тийм байна. Энэ нь муудах байдал дотор таригдаж, үл муудах байдал дотор амилуулагдана. Энэ нь үл хүндлэл дотор таригдаж, цог жавхлан дотор амилуулагдана. Энэ нь мөхөс байдал дотор таригдаж, хүч дотор амилуулагдана. Энэ нь төрөлх биеэр таригдаж, сүнслэг биеэр амилуулагдана. Төрөлх бие байдаг бол сүнслэг бие ч мөн байгаа" гэжээ (1 Коринт 15:42-44).

Бидний одоогийн бие болон үхлээс амилах бие хоёрын хоорондох үргэлжлэх ба үл үргэлжлэх чанарыг бид нарийн тодорхой мэдэхгүй. Есүсийн бие үхлээс амилахдаа өөрчлөгдсөн шиг бидний бие ч мөн өөрчлөгдөх болно. Шинэчлэгдэн, төгс болох болно. Үхэшгүй мөнх, сүр жавхлантай, хүчирхэг бас сүнслэг болох болно. Гэхдээ бас бүхэлдээ хүн хэвээр байна. Үхлээс амилсныхаа дараа л бид эцэст нь нэг юм Бурханы үргэлж төлөвлөсөөр ирсэн тэдгээр хүмүүс болох билээ.

Бидний бие нүглийн улмаас үхдэг. Бие махбодын үхэл бол уналт дахь хүн төрөлхтний хорон муу байдлын эсрэг Бурханы шүүлт юм. Харин Сайнмэдээ бидэнд биеийн амилал сэргэлтийг тунхагласан. Энэ нь Есүс бидний бие ба сүнсийг бүхлээр нь зольж аврахаар ирсэн гэдгийг хэлсэн. Энэ бол сүр жавхлант золилт юм. Энэ бол бидний баярлан хөөрч, тэмдэглэх шалтгаан мөн. Бие махбод маань үхлээс амилсны дараа бид үхлийг ялснаа тунхаглаж чадна. Тэгээд эцэст нь бид шинэ тэнгэр, шинэ газарт Бурханы бидэнд хадгалан буй бүхий л ерөөлийг өвлөн авахад бэлэн болно. Мөн бид Есүс Христийн ялалтыг өөрсдийн нүдээр харж чадах билээ.

Энэ хүртэл бид авралын тухай хичээлээрээ Элч нарын тунхаг дахь нүглийн уучлал болон биеийн амиллын талаарх итгэлийн тунхаглалуудыг авч үзлээ. Тэгэхээр одоо бид сүүлийн сэдэв болох мөнх амийн тухай үзэхэд бэлэн боллоо.

МӨНХ АМЬ

Элч нарын тунхгийн хамгийн сүүлийн итгэлийн тунхаглал нь мөнх амийн тухай байдаг. Энд:

**"Би...
Мөнхийн амьдралд итгэдэг" гэжээ.**

Тунхагт энэ үүрд мөнхийн амьдрал буюу ихэнхдээ мөнх амь гэж нэрлэдэг энэ ойлголтын тухай биеийн амиллын дараа бичсэн байна. Бурханы итгэмжит хүмүүс эцэст нь төгс ерөөгдсөн, ялзрал завхралгүй, хэзээ ч төгсөшгүй амьдралтай болно гэдэг итгэлийг тунхагт баталгаажуулжээ.

Мөнх амийн тухай ярих маш олон зүйл байдаг хэдий ч бид энэ хичээлээрээ гурван асуудалд голчлон анхаарах болно. Нэгдүгээрт, бид үүрд мөнх амьдралын хугацааны тухай ярих болно. Энэ нь яг хэзээ эхлэх вэ? гэдэг тухай юм. Хоёрдугаарт, бид мөнх амьдралын шинж чанарын тухай авч үзнэ. Энэ нь бусад амьдралаас юугаараа өөр юм бэ? Гуравдугаарт, бидний үүрд мөнхөд амьдрах газар маань чухам хаана байх талаар тус тус ярилцана. Ингээд мөнх амьдралын цаг хугацааны тухай эхлээд үзэцгээе.

ХУГАЦАА

Мөнх амь хэзээ эхэлдэг вэ? Христ биднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн гэж хэлсэн байдаг. Христийн дотор байж, Христийн дагалдагч байхыг тэр бидэнд санал болгосноороо Тэрээр бидэнд хамгийн эрхэм дээд сайн сайхан амьдралын замыг зааж өгдөг. Тэгвэл энэ нь мөнх амь мөн гэсэн үг үү? Эсвэл бид энэ зуурдын оршихуйн цаана орших амьдралд шилжих тэр мөчид мөнх амь эхэлдэг юм болов уу? Тэгээд л мөнх амьдрал эхэлдэг гэж үү? Нэг ёсондоо тийм л дээ. Гэхдээ нөгөө талаараа биднийг булшнаас гарган, Бурхантай үүрд мөнхөд хамт байлгах Христийн амилал бүхий шинэ амь амьдрал нь одоо бидний дотор үр болон таригдсан тэрхүү амьдрал билээ. Тиймээс төгсгөлгүй амьдралын эхлэл бол одоо юм. Энэ мөнх амийг зөвхөн эцэс төгсгөлгүй хугацаагаар тодорхойлж болохгүй гэдгийг ойлгох нь чухал. Харин яг одоогийн Христ төвтэй, Бурхан төвтэй амьдралаар, мөн хүн төрөлхтөнд анхнаасаа төлөвлөсөн бүхнийг бүрэн дүүрнээр сэргээгдэх үе рүү тэмүүлж байгаагаар тодорхойлох хэрэгтэй. Тэгээд бид одоохондоо зовлонтой, хатуу ширүүн, эвдэрч сүйдсэн энэ дэлхийд байгаа хэдий ч энэ үйл явцад оролцож байгаа билээ.

-Др. Глен Ж. Скоржие

Итгэгчид мөнх амийг аль хэдийнээ бодитоор хүлээж авсан гэж Библид олон удаа хэлсэн. Бид энэ тухай Иохан 10:28, 1 Тимот 6:12, 1 Иохан 5:11-13 зэрэг олон эшлэлээс харж болно. Иохан 5:24 дээрх Есүсийн хэлсэн үгийг жишээ болгон харцгаая. Энд:

"Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Үгийг минь сонсоод, Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд яллагдахгүй. Харин үхлээс гэтэлж аминд шилжсэн" гэжээ (Иохан 5:24).

Есүс болон Шинэ Гэрээний бичээчид мөнх амь нь Христтэй нэгдсэн нэгдлийн үр дүнд аль хэдийн эхэлчихсэн хэмээсэн байдаг. Мэдээж энэ бол үнэн. Бидний бие махбод үхэх ч сүнс маань хэзээ ч үхэхгүй. Бидэнд одоо байгаа сүнслэг амь нь бидний үүрд мөнхөд үргэлжлэх амь нэг юм.

Нөгөөтээгүүр, Библид мөнх амийг эцсийн шүүлтийн үед өв болгон хүлээн авна хэмээн илүү олон удаа дурдсан байдаг. Матай 25:46, Марк 10:29-30, Иохан 12:25, Ром 12:25, Иуда 21-р бүлэг зэргээс бид үүний тухай харж болно. Иохан 6:40 дээр Иохан энэ тухай юу гэснийг жишээ болгон харцгаая. Тэрээр энд:

"Хүүг харж, Түүнд итгэгч бүр мөнх амьтай байх нь Эцэгийн минь хүсэл юм. Эцсийн өдөрт Би түүнийг амилуулна гэж айлдлаа" (Иохан 6:40).

Энэ эшлэлд Иоханы хэлсэн шиг Библид мөнх амийг бүрэн дүүрнээр хүлээн авах явдлыг ихэвчлэн биеийн амилалтай холбосон байдаг. Бидний бие амилуулагдах үед бидний бие ба сүнс нь бүрэн дүүрэн золигдож, шинэчлэгдсэн хүмүүний хувьд мөнхөд амьдрах болно.

Христтэй нэгдсэн нэгдлээр дамжуулан Христийн дотор хүлээн авдаг зүйлсээ бид "аль хэдийн" ба "хараахан" гэж ангилах нь тун тустай гэж би боддог. Ингэж үзвэл мөнх амь зэрэг Христийн ашиг тусууд Христийг хүлээн авч, Христэд итгэлээ өгөх тэр үед маань "аль хэдийн" биднийх болсон гэсэн үг. Мөнх амь одоо биднийх болсон. Яг үүнтэй зэрэгцэн "хараахан аваагүй" зүйлс бас байгаа. Бид Христийг хүлээн авсныхаа дараа хөгширч, өвчин тусаж, Христ эргэж ирэхгүй бол бидний ихэнх нь үхлийг амсах нь мэдээж. Энэ утгаараа мөнх амийг бид "хараахан" хүлээн аваагүй байна. Тиймээс "аль хэдийн" ба "хараахан" гэж ангилбал бидэнд ойлгомжтой болно. Тиймээ, бидэнд одоо мөнх амь бий. Гэвч бас шинэ тэнгэр газарт мөнх амь биднийг хүлээж байгаа гэсэн үг юм.

-Др. Жеффри К. Жүе

Бидний сүнсний мөнх амь энэ амьдралдаа дахин төрөх үед эхэлдэг гэж хэлэх нь зүйтэй. Гэхдээ эцсийн шүүлтийн үед бидний бие амилуулагдах хүртэл бид бүрэн дүүрэн амьтай болж чадахгүй. Гагцхүү тэр үед л бид Бурханы өмнө бүрэн дүүрэн амьтай байх болно. Харин түүнээс өмнө бол бид сүнснийхээ золилтоор дамжуулан мөнх амийн амталгааг л амсаж мэдэрдэг юм. Харин бие маань шинэ амьтай болж байж л бид Бурханы хүсэж төлөвлөсний дагуу амьдарч чадна.

Бид мөнх амийн цаг хугацааны тухай үзлээ. Одоо бүгдээрээ онцлог шинж чанарынх нь тухай авч үзье.

Онцлог чанар

Библи дэх мөнх амь бол зөвхөн үүрд мөнхөд үргэлжлэх оюун ухаан эсвэл оршихуйн тухай асуудал биш юм аа. Эцсийн эцэст, Бурханы үүрд мөнхийн шүүлт дор байгаа хүмүүс хүртэл ухамсартайгаар оршин байсаар байдаг шүү дээ. Харин мөнх амьдралын гол шинж чанар бол Бурханы ерөөл дотор мөнхөд амьдрах явдал мөн. Энэ утгаараа амьтай байна гэдэг нь Бурханы таалал болон ерөөлийг хүртэнэ гэсэн үг. Харин эсрэгээрээ үхлийг амсах нь Түүний уур хилэн болон хараал дотор байна гэсэн үг юм. Мөнх амь ба мөнх үхэл хоёулаа үргэлжид оршино. Харин энэ хоёрын ялгаа нь ямар шинж чанартай оршиж байгаад буй юм. Иохан 17:3-р эшлэлд Есүсийн ийнхүү залбирсан байдаг. Тэрээр:

"Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнх амь мөн" гэжээ (Иохан 17:3).

Энэ эшлэлд Есүс мөнх амь бол Бурханыг болон Есүсийг таньж мэдэх явдал юм гэж заажээ. Энд буй таньж мэдэх гэдэг нь хайрын харилцааг илэрхийлж байна. Есүс энд мөнх амь нь зөвхөн ухамсар ба оршихуйгаар тодорхойлогдохгүй, харин Бурханы хайрыг амсаж мэдрэх явдал юм гэжээ.

Мөн Ром 7:9-11-р эшлэлд Паул амь ба үхлийн талаар юу гэж хэлснийг харцгаая. Тэрээр энд:

"Нэгэн цагт би хуульгүйгээр амьд байлаа. Гэтэл тушаал ирснээр нүгэл амилж, би үхэв. Тэгээд би амийг амласан тушаал нь үхэлд хүргэдгийг мэдлээ. Учир нь тушаалаар шалтаглаж нүгэл намайг мэхэлсэн бөгөөд намайг түүгээр алсан" гэжээ (Ром 7:9-11).

Үүнийг тайлбарлаж байхдаа Паул бие махбод болон оюун санааны хувьд амьд байсан. Тэрээр ухамсартай, ухаалаг хүмүүний хувьд оршин байсан. Тэгсэн ч тэрээр эхэндээ амьд байсан, дараа нь үхсэн гэжээ. Өөрөөр хэлбэл Түүнийг үхэлд хүргэсэн гэж хэлсэн байна. Ялгаа нь тэрээр Бурханы өмнө байсан. Хууль түүнийг яллахаас өмнө тэрээр амьд байсан. Гэвч хууль түүнийг Бурханы хуулийн хараал дор оруулж, Паул үхсэн. Дараа нь тэр Христ дээр ирж, хараал нь үгүй болсноор шинэ амьдралтай болсон гэжээ. Энэ талаар бид Иохан 5:24, 1 Иохан 3:14 зэрэг эшлэлээс харж болно.

Үүнийг ингэж бодож үзье л дээ. Эцсийн өдөр үхсэн бүх хүн бүх нийтийн амиллаар амилах болно. Бидний мөнх сүнс үхлээс амилсан биетэйгээ дахин нэгдэнэ. Иохан 5:28-29-р эшлэлийн дагуу сайныг үйлдсэн нь амийн амилалд, муу муухайг үйлдсэн нь ялын амилалд байх болно гэжээ. Тэдний аль аль нь амилсан биедээ үүрд ухамсартай амьдрах болно. Харин Библид зөвт хүмүүсийн тавиланг “амь”, ёр муу хүний тавиланг “үхэл” гэж нэрлэдэг. Тэдний ялгаа бол оршин байх, бодох сэтгэх, мэдрэх эсэхэд биш юм. Тэдний ялгаа нь Бурхантай харилцах харилцаанд оршдог. Хэрэв бид Бурханы ерөөл дор байвал амьд байна гэсэн үг гэж Библи хэлсэн. Харин Түүний хараал дор байгаа бол үхсэн гэсэн үг. Тиймээс мөнх амь гэдэг бол Бурхантай харилцах ерөөлтэй харилцаанд ухамсартайгаар үргэлжлэн орших явдал юм. Гэхдээ тэр ерөөлүүд нь юу юм бол? Ерөөлтэй амьдрал ямар байдаг юм бол?

Бид Бурхантай хамт үүрд мөнх үргэлжлэх амьдралаа үүлэн дээр хөвөх мэтээр төсөөлж болохгүй гэж би боддог. Харин бид гэм нүгэл, өвчин зовлон, үхэл хагацлаас ангид цоо шинэ амилсан биетэй болсон байх болно. Бид үхэшгүй мөнх болж, хэзээ ч үхэхгүй. Мөн бид шинэ газарт амьдрах болно. Гэхдээ нарийн зүйлсийг мэдэхгүй л дээ. Яг чухам ямар байх юм бол оо? Бүгдийг нарийн мэдэхгүй ч бид ямар нэгэн үүрэг хариуцлагатай байна гэдгийг бол мэднэ. Бид Христтэй хамт хаанчлах болно. Энэ нь шинэ газар байх учраас бид Бурханы бүтээсэн сансар огторгуйтай харилцах байх гэж би боддог. Тиймээс мэдээж бас бидэнд хийх тодорхой зүйлс байх ёстой гэж би төсөөлдөг. Угаасаа Шинэ Гэрээнд бидний хийх зүйлсийг төдийлөн онцолж авч үзээгүй байдаг. Үнэхээр сонирхолтой шигээ гайхалтай бас сэтгэл ханамжтай байна гэдэгт л би итгэж байна. Харин Шинэ Гэрээ нь

Бурхан бидэнтэй хамт байхыг л онцолдог юм. Бид Түүний нүүр царайг харна. Түүнтэй нөхөрлөх нь бидний бүхий л баяр хөөр байх болно.

-Др. Томас Р. Шрайнер

1957 оны үед амьдарч байсан алдарт теологич Луйс Беркоф Системт теологи хэмээх номынхоо 6-р бүлгийн 5-р хэсэгт мөнх амийн эцсийн төлөв байдлыг дүрсэлсэн байдаг. Түүнийг юу гэж бичсэнийг сонсоцгооё. Тэрээр энд:

Энэ амьдралын утга учир нь Бурхантай холбоотой байхын аз жаргал юм... Тэд Есүс Христийн дотор Бурхантай нүүр нүүрээрээ учирч, Түүн дотор бүрэн дүүрэн сэтгэл ханамжтай байж, Түүн дотор баярлан хөөрч, бас Түүнийг алдаршуулан хүндлэх болно... Танин мэдэхүй болон нийгмийн харилцаа дээд түвшинд хүрнэ... Мөн хүн бүрийн баяр жаргал төгс бүрэн дүүрэн байх болно.

Зарим талаараа Библид мөнх амийн мөн чанарын тухай төдийлөн дурдаагүй байдаг нь хачирхалтай санагддаг байх л даа. Гэхдээ мөнх амь бол Христийн дотор гэмшиж, авралд хүргэх итгэлтэй болсон хүмүүст Сайнмэдээний өгдөг агуу шагнал юм. Харин Библид мөнх амийн тухай маш ерөнхий зүйлс заасан байдаг. Илчлэл 21:3-4-р эшлэлд Бурхан Өөрийн хүмүүстэй хамт оршиж, ямар ч үхэл ба шаналал үгүй болно гэж хэлсэн. Бид шинэ биетэй болж, гэм нүглийн сүүдэр, завхрал, нөлөөнөөс бүрэн ангижрах болно. Гэвч чухамдаа яг ямар байх бол? Даанч үнэндээ Библид энэ талаар тун цөөхөн дурдсан байдаг. Үүний оронд Бурхан бол сайн гэдэгт итгэж, Түүний бидэнд бэлдсэн гайхамшгуудын талаар хэт их таамаглал дэвшүүлэхгүй байхыг голчлон урамшуулдаг. Энэ тухай 2 Коринт 12:2-4-р эшлэлд Паул юу гэж бичсэнийг харцгаая. Тэрээр энд:

"Би Христ доторх нэгэн хүнийг мэднэ. Тэр ...гурав дахь тэнгэрт аваачигдсан юм... диваажинд аваачигдсаныг нь болон хүний илэрхийлшгүй, хэлж боломгүй үгсийг сонссоныг нь мэднэ" гэжээ (2 Коринт 12:2-4).

Тэр хүний юу амсаж мэдэрсэн талаар Паул юу гэж хэлснийг сайн анзаараарай. Сонссон зүйлс нь илэрхийлэхийн аргагүй буюу тэдгээрийг хүний хэлээр хангалттай илэрхийлэх боломжгүй байв. Түүнээс гадна тэр хүнд гуравдагч тэнгэрт яг юу байдгийг хэлэх зөвшөөрөл байхгүй байсан байна. Бурхан одоохондоо үүнийг нууцалж байгаа нь үнэхээр гайхамшигтай.

Энэ нь зөвхөн амиллаас өмнөх завсрын үеийн тэнгэрийн улсын тухай өгүүлсэн байна шүү дээ. Тэнгэрийн улсын нууцыг илчилж болохгүй байхад эцсийн тэр үеийн тухай ямар их нууц байхыг төсөөлж байна уу? Христ эргэн ирсний дараах амьдрал ямар гайхамшигтай болохыг хэн төсөөлж чадах вэ? Библи бидэнд ямар ч уй гашуу, зовлон шаналал, үхэл хагацал байхгүй гэж хэлсэн. Тийм байх нь үнэхээр гайхамшигтай бас үнэн. Гэвч Библи бидэнд үүнээс илүү нарийн дэлгэрэнгүй зүйлсийг хэлж өгөөгүй билээ.

Тэгэхээр бүгдээрээ үүрд мөнхийн амьдралын хугацаа болон шинж чанарынх нь тухай авч үзлээ. Одоо сүүлийн сэдэв болох бид чухам хаана мөнхийн мөнхөд амьдрах талаар судалцгаая.

БАЙРШИЛ

Шинэ тэнгэр, шинэ газар бий болж, бид үүрд мөнхөд амьдрах тэр газрын тухай Библид олонтоо дурдсан байдаг. Бид энэ талаар Исаиа 65:17, 66:22, 2 Петр 3:13, мөн Илчлэл 21:1 зэрэг эшлэлүүдээс харж болно. Тэнгэр газрыг дахин бүтээх энэ үе бол Библийн түүх бүрэн гүйцэд биелэх үе юм. Энэ түүх нь Эхлэл 1:1-р эшлэлд Бурхан тэнгэр газрыг бүтээснээр эхэлсэн. Гэвч энэ нь хүн төрөлхтний уналтаас болж завхран, Бурхан оршин байхад тохиромжгүй газар болсон юм. Библийн үлдсэн хэсэг нь хүн төрөлхтөн болон бүтээл хоёулаа хэрхэн золигдож байгаа тухай өгүүлдэг. Эцэст нь Есүс эргэж ирснээр тэнгэр ба газар дэлхий золигдон, шинэчлэгдэх болно. Тийнхүү Бурхан үхлээс амилсан Өөрийн хүмүүсийн хамт газар дэлхий дээр орших болно. Энэ бол Матай 6:9-10-д буй Эзэний заасан гуйлт дахь Есүсийн хэлэх гэсэн санаа юм. Энд:

“Тэнгэр дэх, бидний Эцэг ээ, Таны алдар ариунаар дуурстугай. Таны хаанчлал иртүгэй. Таны таалал тэнгэрт шигээ Газарт бас биелтүгэй” гэдэг (Матай 6:9-10).

Хамгийн гол зорилго бол Тэнгэрэлч нар болон тэнгэрт хальсан ариун хүмүүсийн оршин байдаг тэнгэрийн улсад ч, бидний амьдарч буй газар дэлхий дээр ч Бурханы хаанчлал бүрэн дүүрэн байгуулагдах явдал байсан. Энэ бол Есүс яагаад хаанчлалаа газарт авчрахыг Бурханаас гуйж, хүсэл нь тэнгэрт шигээ газарт ч бас биелэх болтугай хэмээн залбирахыг бидэнд заасан гол шалтгаан юм.

Хэдийгээр Бичвэрт энэхүү шинэ бүтээлийн талаар тэр бүр ярьдаггүй ч золигдсон хүн төрөлхтөн тэнгэрт биш, харин шинэчлэгдсэн газар дэлхий дээр амьдарна гэдэг нь тун тодорхой байдаг. Тухайлбал, Исаиа 65:17-19-р эшлэлээс Бурханы хүмүүс шинэчлэгдсэн ариун хот Иерусалимд амьдрах болно гэдгийг олж мэддэг. Илчлэл 21:1-5-р эшлэлд Иохан юу гэж бичсэнийг сонсоцгооё. Энд:

"Би шинэ тэнгэр, шинэ газрыг харлаа... Ариун хот, шинэ Иерусалим нь ...Бурханаас гарч, тэнгэрээс буун ирэхийг би харлаа.Сэнтийнээс гарах чанга дууг би сонсов. —Харагтун, Бурханы асар хүмүүсийн дунд байна. Тэр тэдний дунд нутаглах болно. Тэд Түүний ард түмэн болж, Бурхан Өөрөө тэдний дунд байж [Бурхан нь болно]...Сэнтийд Залрагч —Харагтун, Би бүх юмсыг шинэ болгож байна..." гэжээ (Илчлэл 21:1-5).

Энэ эшлэлд Бурхан тэнгэрт Шинэ Иерусалимыг бэлтгэж байгаа гэсэн байна. Шинэ газар дэлхий бэлэн болох үед Тэрээр Шинэ Иерусалимыг газарт авчирч, Өөрийн хүмүүсийн дунд хамт оршин байх юм. Бурхан биднийг зүгээр л тэнгэрт мөнхөд амьдруулах төлөвлөгөөтэй байсан бол шинэ газар дэлхийг бүтээх хэрэг байхгүй шүү дээ. Харин бид энэ эшлэлээс Бурхан бидний мөнхийн гэр орон болох энэ дэлхийг оролцуулаад бүхнийг шинээр бүтээх юм.

МЭ 354-430 оны хооронд амьдарч байсан Хиппогийн алдарт бишоп, Сүмийн анхны эцэг Августин Бурханы Хот хэмээх алдарт бүтээлийнхээ 20-р боть, 16-р бүлэгт шинэ газар дэлхийн тухай бичсэн байдаг. Тэрээр энд:

Газар дэлхий өөрөө илүү дээр болж шинэчлэгдээд махбодоороо илүү дээр болж өөрчлөгдсөн хүмүүс амьдрахад тохиромжтой болно.

Бурхан бүх зүйлийг шинэчлэх өдөр ойртож байна. Бид үүнийг Есүсийн бидэнд болон дагалдагч нартаа заасан гуйлт залбирлаас харж болдог. Энд Тэрээр "Тэнгэр дэх, бидний Эцэг ээ, Таны алдар ариунаар дуурстугай. Таны хаанчлал иртүгэй. Таны таалал тэнгэрт шигээ Газарт бас биелтүгэй" гэжээ. Энэхүү Христитгэлийн амин чухал, үндсэн гол ойлголт бол тэнгэрлэг бодит үнэн нь дэлхийн бодит байдал болохыг хүлээж буй цаг үед бид амьдарч байгаа явдал юм. Энэ нь тэнгэрт Бурхан алдаршихад мөн бүх зүйл зөв зохистой болж, зөвт байдал ба сүр жавхлан, үнэн ба хайр хаанчлахад бий болдог зүйлс билээ. Христитгэгчдийн хувьд бидний найдвар, бидний бат найдвар бол тэнгэрийн улсын тэрхүү бодит байдал газар дэлхийн бодит байдал болох явдал юм. Мөн энэ бол бидний мөнхийн гэр болох шинэ бүтээлийн талаарх Бичвэрийн амлалт ба найдвар мөн.

-Др. Жонатан Т. Пеннингтон

Шинэ газар дэлхий нь бидний эцсийн гэр орон болно гэдэг үнэнийг бид ойлгохгүй бол бодит байдлын талаарх үнэнийг ялгаж салгахаа больдог. Тэгээд газар дэлхий дээр биеэрээ оршин байх нь ерөөл биш харин хэцүү зовлон гэж бодоход хүрдэг. Харин бид газар дэлхий нь бидний мөнхийн гэр орон болно гэдгийг ойлговол одоогийн энэ дэлхийгээ ерөөл гэдгийг харж, удахгүй ирэх дэлхийд Бурханы бидэнд зориулан бэлдсэн зүйлсийг урьдчилан амталж чадах юм.

ДҮГНЭЛТ

Элч нарын тунхгийн тухай энэхүү хичээлээрээ бид авралын тухай сэдвийг анхаарч судаллаа. Бид гэм нүглийн уучлалын талаар ярилцахдаа гэм нүглийн асуудал болон тэнгэрлэг нигүүлслийн бэлгийн тухай, мөн хүний өөрийн үүрэг хариуцлагын тухай үзсэн. Мөн бид биеийн амиллын тухай онол сургаалыг үхлийн хараал, амийн Сайнмэдээ, Христийн золилт гэсэн хэсгүүдэд хуваан судалсан. Түүнчлэн бид мөнх амийн мөн чанарыг цаг хугацаа, шинж чанар, байршил гэсэн талаас авч үзлээ.

Авралын тухай энэ хичээлээрээ бид Элч нарын тунхаг нь чуулганы мянган жилийн туршид хадгалан ирсэн Христитгэлийн нийтлэг итгэл үнэмшлийн амин чухал хэсгүүдэд төвлөрч байгааг олж харсан. Хэрэв бид янз бүрийн уламжлал ба урсгал чиглэлийн Христитгэгчидтэй ярихдаа эдгээр онол сургаалуудыг мэдэж байвал Элч нарын тунхагт итгэдэг хүн бүртэй бат суурьтай нэгдлийг бий болгож чадна. Мөн итгэдэггүйг нь засаж залруулж чадах юм. Үүнээс гадна авралын онол сургаалын эдгээр чухал зүйлсийг анхаарч үзсэнээр Бурхан энэ дэлхийд юу хийж байгааг том зургаар нь харж, Түүний хайр ба нигүүлслийг магтан хүндлэх илүү олон шалтгаантай болох билээ.

ХАМТРАГЧИД

Др. Ван Гэйтон (хөтлөгч) бол Виллиамс Библийн Институтийн салбарын захирал, дэлхий даяарх өөр олон сургалт болон их сургуулиудад Библийн багш, илтгэгч. Др.Гэйтон нь мөн Холбооны Шоронгийн товчооны эрхлэгчээр 4 жил үйлчилсэн. Мөн Вашингтоны Шашин ба Олон нийтийн бодлогын институтийн захирлуудын зөвлөлд байсан. Др.Гэйтон нь Олон улсын Семинар сургуулийн Теологийн мастер, Логос Библийн Коллежээс Шашны мастер, Христитгэлийн Удирдлагын Их Сургуулийн Библийн философийн доктор, Фэйт теологийн семинарийн Теологийн доктор, Реформэд теологийн семинарын Үйлчлэлийн доктор зэргийг тус тус хамгаалжээ. Мөн тэрээр Апостолик Саксэшинд бишопоор томилогдож байсан. Христийн Биеийн түүхэн нэгдлийг сэргээх зорилготой Христитгэлийн чуулгануудын Олон улсын Коммунитигийн Аркбишопоор үйлчилж байсан.

Dr. Knox Chamblin (1935-2012) served as Professor of New Testament at Reformed Theological Seminary.

Dr. J. Ligon Duncan III is Chancellor and CEO of Reformed Theological Seminary and the John E. Richards Professor of Systematic and Historical Theology.

Dr. John M. Frame is Professor Emeritus of Systematic Theology and Philosophy at Reformed Theological Seminary in Orlando, Florida.

Dr. Jeffrey K. Jue is Executive Consultant at Westminster Theological Seminary after having served there previously as Provost, Executive Vice President and Professor of Church History.

Dr. Robert G. Lister is Associate Professor of Biblical and Theological Studies at the Talbot School of Theology.

Dr. R. Albert Mohler, Jr. is President of The Southern Baptist Theological Seminary.

Dr. J. I. Packer (1926-2020) was Board of Governors' Professor of Theology at Regent College in Vancouver, British Columbia and preached and lectured widely in Great Britain and America.

Dr. Jonathan T. Pennington is Associate Professor of New Testament Interpretation and the Director of Research Doctoral Studies at The Southern Baptist Theological Seminary.

Dr. Thomas R. Schreiner is the James Buchanan Harrison Professor of New Testament Interpretation and Associate Dean of Scripture and Interpretation at The Southern Baptist Theological Seminary.

Dr. Glen G. Scorgie is Professor of Theology at Bethel Seminary, San Diego.

Dr. Mark L. Strauss is Professor of New Testament at Bethel Seminary, San Diego.

Dr. Derek Thomas is Professor of Systematic and Historical Theology at Reformed Theological Seminary in Atlanta, Georgia.

Dr. Stephen J. Wellum is Professor of Christian Theology at The Southern Baptist Theological Seminary.

ҮГСИЙН ТАЙЛБАР

Аугустин - (МЭ 354 – 430 он) Бичвэр нь онол сургаалын эцсийн дээд эрх мэдэл гэдэгт итгэдэг, чуулганы тунхгуудыг бичвэрийн сургаалын хураангуй хэмээн сайшаан үздэг байсан Хиппогийн бишоп. Тэрээр өнөөгийн чуулганд ч нөлөө үзүүлсээр буй олон зүйлс бичиж үлдээсэн.

Лоуис Беркхоф- (1873-1957 он) 1932 онд *Системт Теологи* гэдэг номыг бичсэн, нөлөө бүхий Шинэчлэлийн теологич

Эмтэрсэн зүрх – Нүглийн төлөөх жинхэнэ гашуудал, Бурханы хуулийг зөрчсөндөө үнэнээр харуусах харуусал

Мөнх амь- Бурханыг таньж мэдээд, Түүний бүрэн дүүрэн ерөөлд өнө мөнхөд амьдрах явдал

Итгэл- Бурханд итгэх итгэлийн тухайд энэ нь Бурханы тэнгэрлэг дээд эрх мэдлийг хүлээн зөвшөөрч, Түүнд үнэнчээр захирагдаж, Тэрээр Золигч Есүс Христийн улмаас бидэнд энэрэл өршөөлөө үзүүлнэ гэдэгт итгэх явдал

Ерөнхий амилал- Христ алдар дотроо эргэн ирэх үед Бурханы эцсийн шүүлтийн өмнө зогсохоор амилах бүх хүмүүсийн амилал

Алдаршуулал – бидний авралын эцсийн шат буюу нүгэл ба үхлийг бүрэн ялснаар төгс мөнхийн биеийг хүлээн авч, хувь тавиландаа бүрэн дүүрэн хүрэх үе

Авралын зар/gospel - шууд утгаараа “Сайнмэдээ” буюу Бурханы хаанчлал нь Есүсийн бодгаль ба үйлсээр дамжуулан газар дээр ирчхээд байгаа бөгөөд Есүсийг Мессиа гэдэгт итгэн, хүлээн авагсад Бурхан авралыг баталгаажуулснаар энэ нь бүрэн төгс болох үе рүүгээ өргөжин тэлсээр буй тухай тунхаглал

Нигүүлсэл- зохисгүй нэгэнд үзүүлж буй Бурханы таалал

Зуучлан залбирал- залбирлаар дамжуулан бусдын өмнөөс гаргаж буй хүсэлт ба гуйлт

Завсрын байдал- дэлхий дээрх өнөөгийн амьдрал болоод амилал дахь ирээдүйн амьдралын хоорондох үе

Ариун ёслолууд- Итгэлээ илэрхийлж, Бурханаас ерөөлийг хүлээн авах арга зам болгон Бурханаас тогтоож өгсөн ёслолууд болох Усан баталгаа ба Эзэний зоогийг хэлнэ

Садукайчууд- Зөвхөн Мосегийн бичсэн таван номыг (Эхлэл- Дэд хууль) баримталдаг бөгөөд тэнгэр элч, сүнс ба үхэгсдийн амилалд итгэдэггүй, Есүсийн үеийн Иудейн шашны бүлэг

Аврал- Есүс Христийн амьдрал, үхэл, амиллаар дамжуулан ёр муугийн дарлал ба нүглийн эсрэг Бурханы шүүлтээс чөлөөлөгдөх явдал

Шеол/sheol - Нас барсан зөвт ба хорон муу хүмүүсийн аль алиных нь сүнс очдог газрыг хэлдэг Хуучин Гэрээн дэх Еврей нэр томьёо (галиглал) .

Нүгэл – ёс бус байдал буюу Бурханы хуульд нийцэхгүй байх эсвэл зөрчил явдал

Чарлес Спөржеон- (1834-1892) 19-р зуунд амьдарч байсан Английн пастор ба бичээч бөгөөд түүнийг “Номлогчдын Ханхүү” гэж нэрлэдэг.

Жон Весли- (1703-1791) Английн санваартан, теологич, Методист Чуулганыг үндэслэгчдийн нэг

Вестминстерийн Товч Катехизм буюу асуулт хариулт – 1647 онд анх хэвлэгдсэн Христитгэлийн сургаалын протестант уламжлалын хураангуй